

# ХАМТДАА УНШЪЯ

Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж

(бага насны хүүхдэд ном уншиж өгөх тухай)

# ГАРЧИГ

I. Яагаад заавал ном уншиж өгөх гэж? 6-15

II. "Хүүхдэд ном уншиж өгөх" хуучин ба шинэ хандлага 16-22

III. Хүүхдэдээ уншиж өгөх ном зохиолоо хэрхэн сонгох вэ? 23-37

IV. Уншиж өгөхөд учир бий 38-53

V. Эцэг эхчүүдийн нийтлэг асуултууд 54-60

Төгсгөлийн үг 61

# ӨМНӨХ ҮГ

Та хүүхдээ ном үзэхэд арай балчирдана гэж бодож магадгүй. Харин ч эсрэгээрээ, ном үзэж эхлэхэд эртдэнэ гэж байдаггүй гэдгийг мэргэжлийн хүмүүс баталсаар байна. Хүүхэд аавынхаа эсвэл ээжийнхээ өвөр дээр суугаад хамтдаа номын зураг үзэн өөрт нь зориулан ярих, уншихыг сонсож байхдаа тэднийхээ хайр халамжийг мэдэрч эерэг харилцаанд суралцахын зэрэгцээ олон чухал чадваруудыг эзэмшиж байдаг юм.

Бид аав ээжүүддээ зориулан хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн үе шатуудын онцлог, хамтдаа ном үзэж, харилцан ярилцаж хэвших нь хүүхдийн хөгжилд ямар нөлөөтэй болох, тэдэнд ном уншиж өгөхдөө юуг анхаарах хэрэгтэй талаар энэхүү зөвлөмжийг бэлтгэлээ.

Зураг болон үгийн шидэт ертөнцөөр хамтдаа аялж, олон сайхан цаг мөчийг үр хүүхэдтэйгээ өнгөрүүлээрэй.




Жаахан хүүхдэд номын хэрэг гэж юу байхав. Уншиж сурах болоогүй байхад?
Тэр үнэн. Гэхдээ тэр таны ярихыг сонсож хамтдаа зураг үзэх тун дуртай.


Надад хүүхэдтэй ном үзээд суух зав алга. Хийх юм их байхад...
Хайртай хүүдээ багахан цаг гаргаж чадахгүй гэж үү?
Өдөрт 10-30-хан минут л хангалттай.

Би өөрөө уншихдаа тийм
ч сайн биш бол яахав?

Энэ бол тийм ч
чухал биш, зургийг
нь харж байгаад
сэтгэлээсээ яриад
өгөхөд л хангалттай.



Зурагтай ном бол хайрцаг
дүүрэн тоглоом л гэсэн үг.
Тэгээд хаана л бол хаана
бариад явж үзэж болно.

















# I
# ЯАГААД ЗААВАЛ НОМ УНШИЖ ӨГӨХ ГЭЖ?

## Яагаад заавал ном уншиж өгөх гэж?

Эцэг эх болгон хүүхдийнхээ хайртай аав ээж нь байхын зэрэгцээ бас анхны багш нь, үлгэрлэн дагуулагч нь болж байдаг. Тийм ч учраас эцэг эхчүүд хүүхдээ хэрхэн дэмжиж хөгжүүлэх вэ? гэсэн асуултыг байнга тавьдаг. Үүний тулд тэр бүр олон төрлийн тоглоом, сургалтын хэрэгсэл худалдаж авах шаардлагагүй юм. Гагцхүү хүүхдээ сэтгэл зүрхнээсээ сонсч ойлгон, тэдэнтэйгээ хамт цагийг хөгжилтэй өнгөрөөж, сонирхол занг нь улам бадраах байх нь хамгаас чухал. Хүүхэдтэйгээ хамт зурагтай ном үзэж, харилцан ярилцаж хэвших нь тэдний хөгжил төлөвшлийг олон талаар дэмжих нэгэн чухал тохиромжтой аргуудын нэг юм. Энэ нь орчин үеийн дэвшилтэт техник мэдээллийн хэрэгслүүдтэй (телевиз, радио, интернет, гар утас, цахим тоглоом гэх мэт) харьцуулахад илүү давуу талтайг мэргэжлийн хүмүүс байнга анхааруулдаг. Техник хэрэгсэл таны хүүхдэдээ хандах халуун дотно харилцааг хэзээ ч орлож чадахгүй нь ойлгомжтой.

## Хүүхэдтэйгээ хамт "ном үзэх" есөн шалтгаан

Бага насны хүүхдийн номонд зураг хамгийн гол үүрэгтэй. Номын зураг харж ажиглан, ойлгох явцыг унших явцтай адилтгаж болно. Гэхдээ зургийг “уншина” гэдэггүй “үзнэ” гэж ярьж хэвшсэн болохоор номын зургаа харж, ойлгож байгаа үйлдлийг “ном үзэх” гэсэн үгээр нэрлэлээ. Гэхдээ энэ нэр томьёог зураг үзэхээс хамаагүй өргөн хүрээнд ойлгох учиртай.

## 1. Тантай хамт суугаад ном үзэх хэсэгхэн мөчид халуун дотно харилцаа үүсч, зугаатай таатламжтай сэтгэгдэл төрж, сэтгэл зүрхээрээ олон зүйлийг мэдрэх нь хүүхдэд эерэг зан чанар төлөвших нөхцөлийг бүрдүүлдэг.

"Үг ойлгохгүй нялх хүүхдэд ном уншиж өгөх хэрэг байна уу?" гэж хүмүүс боддог. Гэтэл төрөөд хэдхэн хоног байгаа хүүхэд ч гэсэн дуу чимээ, үг яриаг сонсож, утгыг нь ойлгохгүй ч сонсохыг хичээж байдаг байна. Японы Хитачи корпорацийн судалгааны төв Италийн эрдэмтэдтэй хамтран, төрөөд тав хоног байгаа нялх хүүхдүүдэд хандан эх хэлээр нь ярьж, мөн ойлгогдохгүй дуу чимээг сонсгож туршихад хүүхдийн тархины зүүн хэсэгт хэл ярианы хөгжилтэй холбоотой их тархины хажуугийн дэлбэн идэвхтэй ажиллаж байгааг илрүүлжээ. Ингэхэд нярай хүүхдийн тархины хажуугийн дэлбэн үг ойлгодог том хүүхдийнхтэй яг адилхан ажиллаж, ойлгогдохгүй дуу чимээнээс төрөлх хэлнийхээ үг ярианд илүү хүчтэй хариу үйлдэл үзүүлж байв. Тэгэхээр дөнгөж саяа төрсөн хүүхэд ч үг ойлгодог хүний адил сонсъё гэж хүсч, тархины үйл ажиллагаа нь идэвхжиж байдаг байна. Мөн ээж нь хүүхдэдээ ном уншиж өгөхөд хүүхдийн тархины аль хэсэгт нөлөөлдөг болохыг Японы хэсэг эрдэмтэд судалж тархины гүн хэсэгт орших сэтгэл хөдлөлийн хэсэг идэвхжиж байгааг тогтоожээ. Эдгээр эрдэмтэд тархины гүнд орших энэ хэсгийг "сэтгэлийн тархи" гэж нэрлэсэн байна. Энэ нь баярлах, уурлах, айх зэрэг сэтгэл хөдлөлтэй холбоотой хэсэг юм. Тэгэхээр хамгийн хайртай хүнээрээ ном уншуулах нь хүүхдийн сэтгэлд хүрч хүүхэд



сэтгэлийн таашаал цэнгэлийг авч байдаг байх нь. Бас ээж нь хүүхдэдээ ном уншиж өгөх үед ээжийн их тархины духны дэлбэнгийн хэсэг энгийн чангаар унших үеэсээ илүү идэвхтэй ажиллаж байгааг тогтоожээ. Шалтгаан нь ердөө л хүүхдэдээ хайртай учраас илүү их сэтгэлээ шингээн мэрийж байгаатай холбоотой юм. Хүний тархи гэдэг сайн ажиллаж идэвхжиж байж л цусны эргэлт нь хурдсан эрүүл саруул байдлаа удаан хадгалж чаддаг. Тэгвэл хүүхдэдээ зориулж унших нь ээжид, аавд ч хүртэл өөрт нь сайн гэсэн үг. Хүүхэд зөвхөн өөрт нь зориулж цаг зав гарган сонирхолтой зугаатай зүйлс хамтдаа үзэж, ярилцаж байгааг анзаарч багаасаа бусдаар хүлээн зөвшөөрөгдсөн бие хүн гэдгээ мэдэрч, өөртөө итгэх итгэл нь нэмэгддэг байна. Аав ээжийнхээ хайрыг өвөр дээрээс нь биеэрээ мэдэрч тэдний нөмөр нөөлөг, өөрийг нь гэх сэтгэлд улам итгэлтэй болно. Номын агуулгаас хүүхэд янз бүрийн асуулт урган гарч ирдэг. Ахин дахин асууж ярилцсаар цаашид эцэг эхтэйгээ байнга харилцаж, өөрт тулгарсан асуудлаа тэдэнтэй хуваалцаж заншина. Орчин үед хүнтэй олигтой мэндэлж чадахгүй, бодож байгаагаа хүнд ойлгуулж чаддаггүй хүүхдүүд олон болж байгаа нь бусадтай шууд харилцахгүй зурагт, компьютер техник хэрэгслээр ихээхэн саатах болсонтой холбоотой. Түүнээс гадна номын үйл явдлаас хөндлөнгийн хүмүүсийн тухай сонсож, нийгэм дэх хүмүүсийн олон янзын харилцааг таньж мэдэн, бусдын хүсэл



сонирхлыг хүндэтгэж сургаг. Сайн хүн болж боловсроход тус болдог олон зүйлс номонд шингэсэн байдаг. Номын дүрүүдийн эмгэнэлт, гунигт түүхийг сонсоод сэтгэл нь өвдөхгүй хүүхэд гэж байхгүй. Харуусах, айх, бахархах, баярлах гэх мэт нарийн мэдрэмжийг номын үйл явдлаас мэдэрч, амьдрал, хүмүүс, өөрийнхөө талаар эргэцүүлэн бодно. Үүгээрээ ном хүний сэтгэлийг ойлгодог нинжин сэтгэлтэй жинхэнэ хүнийг өсгөхөд тусалдаг юм.



## 2. Эх хэлний мэдлэгт чухал үүрэг гүйцэтгэдэг

Зурагт ном үзэж, сонсож, ярилцах явцад өгүүлбэр бүрээс, зураг бүрээс хүүхэд үгийн сангаа баяжуулж байдаг. Ном байнга уншуулдаг хүүхэд үгийн баялагтай болохоос гадна дүрмийн дагуу зөв, уран яруу үг хэллэгийг шууд хүлээн авч хэрэглэж сургаг. Ийм цэгцтэй зохиолын хэлний өгүүлбэрүүд бидний өдөр тутмын жирийн ярианд төдийлөн хэрэглэгддэггүй учраас хүүхдийг багаас нь бичгийн хэлэнд ойртуулан дасгаж чаддаг. Номтой багаасаа харьцсан хүүхэд уншсанаа ойлгох чадвар сайтай, бусдаасаа яриа, бичгийн хэлийг илүү эзэмшсэн, өөрийнхөө санаа бодол, мэдрэмжийг хүнд зөв ойлгуулах чадвараар илт давуу байдаг нь ажиглагддаг. Хүүхдэд нэн тэргүүнд эзэмшүүлэх чадвар бол эх хэлний чадвар юм. Эх хэлний мэдлэг ямар ч хичээлийн суурь үндэс болно. Уншиж ойлгох чадвар муутай хүүхэд буруу уншиж, буруу ойлгоно. Хичээлийн агуулгаа сурах бичгээс гүнзгийрүүлж авч чадахгүй байсаар хичээл хийх сонирхолгүй болно. Тооны хичээл дээр өгүүлбэртэй бодлогын гол асуудлыг сайн ойлгохгүй бол цааш хэчнээн



хичээгээд ч нэмэргүй. Тэгэхээр хүүхдээ хичээлдээ сайн, толгойгоо ажиллуулж чаддаг болгож өсгөхийн тулд юуны түрүүнд эх хэлний чадварыг нь багаас нь хөгжүүлэх нь чухал. Үүнийг сургуульд ороод хичээл хийснээр биш, бага балчир наснаасаа номонд дуртай байж ном их уншуулснаар, уншсанаар олж авдаг юм.

## 3. Анхаарал төвлөрөлт сайжирдаг

Хүүхдийн сонирхлыг өөрийн эрхгүй татаж зугаацуулдгаараа ном тоглоомтой төстэй гэж болно. Гэхдээ маш анхааралтай сонсож, харж ажиглаж, сэтгэхийг шаарддаг учир хүүхдийн анхаарал төвлөрөлт аяндаа сайжрах хамгийн тохиромжтой нөхцөл бүрддэг. Тэвчээргүй, хөдөлгөөн ихтэй хүүхдэд ч аяндаа анхаарлаа сайтар төвлөрүүлж сурах сайхан боломж болно. Ялангуяа номын үйл явдлаас үргэлжлүүлэн зураг зурах, баримлаар зохиомж, дүрс урлан хийх зэрэг нь хүүхдэд гайхалтай дасгал болж өгнө.

## 4. Ой тогтоолтын дасгал болдог

Хүүхэд өөрийнхөө дуртай номыг олон дахин уншуулсаар үйл явдлыг нь цээжилж тогтоосон байдаг. Ингэж нэг номыг дахин дахин үзэж, уншуулж хэрэглэдэг нь томчуудын номын хэрэглээнээс ялгагдах онцлог юм. Хүүхэд сонсож байгаа зүйлээ зурагт дүрслэгдсэн байдлаар бататган авч, тархиндаа маш бат бөх хадгалан харааны болон сонсголын ой тогтоолтод давхар суралцаж байдаг. Тиймээс хүүхэд нэг л сэдвийг дахин дахин уншуулахыг хүсч байвал битгий төвөгшөөгөөрэй. Хүүхэд нэг номыг

3-6 сарын турш дахин дахин үзэх нь ердийн хугацаа юм.

## 5. Сэтгэхүй хөгжүүлэг

Номын үйл явдлыг хүүхэд ой тойндоо зураглан төсөөлөхөөс гадна ургуулан баяжуулж, урнаар дүрслэн сэтгэдэг бөгөөд энэ байдлыг нь томчууд хөхүүлэн дэмжих хэрэгтэй. Хүүхэд байхаасаа "фантазлах" дуртай, хийсвэр ертөнцөд умбадаг байсан нь хожмоо ажил эрхлэхэд нь төсөөлөх, төлөвлөх чадварынх нь эх булаг, хөдөлгөгч хүч нь болж байдаг гэх хүмүүс олон бий. Мөн сэтгэхүйн үйлдлүүд болох нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, мэдээллээс чухал хэсгийг нь олох чадвар, логик сэтгэлгээ зэрэг нь ном их уншдаг хүмүүст илүү хөгжсөн байдгийг судлаачид тогтоожээ.

## 6. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэг

Хүүхэдтэйгээ ном унших явцдаа асуусан асуултыг нь үргэлж дэмжин, бүрэн гүйцэд хариулт өгөх, өөрөөр нь бодуулах, тухайн үйл явдал ямар байдлаар үргэлжлэхийг төсөөлүүлэх, унших явцдаа болон дуусаад ярилцах, санаа сэтгэгдлээ хуваалцах, хүүхдэд зориулсан нэвтэрхий толиос тухайн сэдвийг лавшруулан уншиж өгөх эсвэл зураг зурах, бүтээл хийх гэх мэтээр идэвхийг нь улам бадраах, өдөөж өгвөл ирээдүйд бүтээлч санаачлага, сэтгэлгээтэй хүн болж төлөвшихөд чухал нөлөө үзүүлдэг.



## 7. Асуудал шийдвэрлэх арга зам болдог

Хүүхдэд элбэг тохиолддог бэрхшээлтэй төвөгтэй асуудлуудыг тусгасан, түүнийг шийдвэрлэсэн агуулгатай ном нь эцэг эхчүүдийн хүүхдээ хүмүүжүүлэхэд их тус болдог. Жишээлбэл: Хүүхэд хоёр нас хүрэхийн алдад бүхий л зүйлийг сониучирхаж, бас хамтын амьдралын холбоо харилцааг анзаарч, мэдэрч эхэлдэг. Гэхдээ үүнийг өөрийн хүсэлтэйгээ зохицуулж хараахан сураагүйгээс аливааг өөрийнхөөрөө хийхийг оролддог. Энэ насны хүүхдэд буруу, зөвийг тайлбарлаж ойлгуулах нь томчуудад тийм ч амархан байдаггүй. Энэ нь хүүхдийн нас балчир, бага байгаатай холбоотой. Харин ойлгуулах гэж буй зүйлтэй холбоотой сэдэвтэй ном, зураг байвал хүүхэд үг асуудлыг тэнд хэрхэн шийдсэнийг яриулаад аяндаа ойлгож, зүгээр хэлж сургаснаас илүү үр дүнтэй байдаг. Номонд бяцхан хүү ангидаа ганцхан байдаг гоё машинаар найзтайгаа ээлжлэн тоглохыг хүсэхгүй, зөвхөн ганцаараа л машинаар тоголмоор байгаа гэх мэт өөрийнх нь амьдралд тохиолддог дүр зургуудыг олж харан гайхшириж, тэнд энэ асуудлыг яаж шийдвэрлэж байгааг дахин дахин яриулсаар хэсэг хугацааны дараа биеэ зөв авч явах, бусад хүмүүсийг хүндэтгэх чадвар аажмаар төлөвшдөг байна.

## 8. Тайвшруулах нөхцөл бүрдүүлдэг

Хүүхэд үдэш унтахаар орондоо орохдоо тийм ч дуртай байдаггүй.Тэд цагийн баримжаа муутай, ядарснаа анзаардаггүй учраас шууд унтахыг хүсдэггүй. Энэ үед тэдэнд аажмаар тайвшруулан унтуулахад тохирсон ном уншиж өгөх нь гайхалтай үр дүн өгдөг. Оройн хоол идсэний дараа хэсэг хугацаанд тоглох, дараа нь юмаа

эмхэлж цэгцлээд шүдээ угааж, орондоо орж хамтдаа ном үзэн үлгэр түүх ярих гэсэн дараалалтай байж болно. Үдэш хүүхдүүддээ үлгэр домог ярьж өгдөг байсан ардынхаа уламжлалыг сэргээн шинэчилж хүүхдийг тайвшруулан унтуулах энэ шалгарсан аргыг амьдралдаа хэрэгжүүлээрэй. Хожим хүүхэд тань сургуульд орж өөрөө уншиж чаддаг болсон ч хааяа дуртай зохиолыг нь уншиж өгч байгаарай. Үүнийг хүүхэд хүссэн хэвээр байдаг юм шүү.



## 9. Гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлдэг

Эцэст нь хэлэхэд хүүхдэд зориулсан зурагт ном төрөл төрлийн мэргэжлийн хүмүүсийн хамтран бүтээсэн урлагийн цогц бүтээл байдгаараа онцлог юм. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулж мэргэжлийн хүмүүсийн бүтээсэн номын агуулга, зураг, хэлбэр дүрс, материал зэрэг нь хүүхдийн анхаарал сонирхлыг татаж тэдний гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлэхэд багагүй нөлөө үзүүлдэг.



# II

# "ХҮҮХДЭД НОМ УНШИЖ ӨГӨХ" ХУУЧИН БА ШИНЭ ХАНДЛАГА

Хүүхдэд ном уншиж өгөх гэдгийг бидний ихэнх нь төсөөлөхдөө: зузаан нүдний шил хамартаа тохсон эмээ юм уу өвөө ном уншаад л уншаад л, хажууд нь сандал дээр суусан хүүхэд чимээгүйхэн чагнаад л чагнаад л байгаа дүр зургийг нүдэндээ хардаг. Тэгвэл энэ ойлголтоос арай өөр, бага насны хүүхдийн хөгжилд олон талын дэмжлэг болдог уншилтын шинэлэг хэлбэр буюу харилцан ярилцаж унших хэлбэрийг олон орны эцэг эхчүүд, сурган хүмүүжүүлэгчид өргөнөөр хэрэглэх болжээ. Харилцан ярилцаж унших гэсэн нэр томьёог анх 1988 онд америкийн эрдэмтэн доктор Гровер Вайтхурст[1] дэвшүүлсэн бөгөөд энэ нь зурагтай ном хамтдаа үзэх насанд хүрэгчи болон хүүхдийн хоорондын харилцааг нэрлэж байгаа юм. Үүндээ харилцан яриаг хамгийн гол байр сууринд тавьж, номын агуулга буюу текстийг хоёрдогч байр сууринд авч үздэг байна. Энэ онолын үндэс нь хамтдаа зурагт ном үзэж байхдаа хүүхдийн хариу үйлдэл бүрийг урамшуулан сайшааж, асуулт асууж, тэдний асуултад хариулах зэргээр аль болох хүүхдийн ярих, бодох, сэтгэх үйлдлийг идэвхжүүлэн дэмжиж туслахад оршдог. Энд харилцан ярилцаж унших явцын гол өгүүлэгч нь насанд хүрэгч биш хүүхэд байдгаараа онцлогтой.Текстийг уран яруу сэтгэл хөдөлгөн унших нь энэ хэлбэрийн уншилтын гол зорилго арай биш. Мэдээж уншигч дуу хоолойгоороо болон нүүр царайныхаа хувирлаар жүжиглэлт үзүүлэх нь хүүхдийн анхаарлыг илүү татна л даа. Энэ бүхнийг гэхдээ дагалдах хүчин зүйл гэж үзээд дахин хэлэхэд идэвхтэй харилцан ярилцах нөхцөлийг бүрдүүлэх нь юу юунаас чухал юм.

[1]АНУ-ын Боловсролын бодлогын газрын институтын захирал байсан бөгөөд түүний удирдлаган доор хийгдсэн олон судалгаа шинжилгээнүүд тухайн салбарын үйл ажиллагаанд өндрөөр үнэлэгддэг. Бага орлоготой өрхийн хүүхдүүдийг сургуульд бэлтгэхэд зориулан боловсруулсан түүний сургалтын хөтөлбөр болох харилцан ярилцаж унших арга барил олон оронд түгэн дэлгэрч, маш амжилттай хэрэгжиж байна.

## Уншиж өгөх хэлбэрүүдийг харьцуулсан нь

| Уламжлалт уншилтын хэлбэр | Харилцан ярилцаж унших хэлбэр |
|---|---|
| Насанд хүрэгчийн оролцоо унших явцын туршид идэвхтэй хэвээр үргэлжилнэ. | Насанд хүрэгч эхлээд идэвхтэй оролцох боловч аажмаар хүүхдийн оролцоог голлох байр суурь луу чиглүүлэн өөрөө зөвхөн идэвхтэй сонсох байдалд шилжинэ. |
| Хүүхэд идэвхгүй оролцогч хэвээр үргэлжилнэ. | Хүүхдийн идэвхтэй оролцоо улам нэмэгдэнэ. |
| Насанд хүрэгч ба хүүхдийн хооронд идэвхтэй харилцаа бараг үүсэхгүй | Насанд хүрэгч хүүхэд хоёрын дунд байнгын идэвхтэй харилцаа үргэлжилнэ. |
| Хүүхдийн асуулт, санал, хэлсэн үг унших үйл явцад саад болдог. | Хүүхдээс асуулт, сэтгэгдэл байнга хүлээгдэнэ. |
| Хүүхдийн хэлсэн үгэнд маш товчхон хариулт тайлбар өгнө. | Хүүхдийн хэлсэн санаа, сэтгэгдэл, үгийг олзуурхан хүлээн авч урамшуулж, хариу тайлбар өгч дэлгэрүүлэн ярилцана. |





## Уламжлалт уншилт

Насанд хүрэгч чангаар уншиж идэвхтэй байхад хүүхэд зөвхөн сонсогч хэлбэрээр идэвхгүй байдалтай оролцдог. Тэд өөрийн санаа бодлоо илэрхийлэх боломжгүй, асуулт асуухгүйгээр зөвхөн үйл явдлыг дагаж сонсдог. Хүүхэд насанд хүрэгчийн яриаг таслан асуулт тавих, үг хэлэх нь саад болсонд тооцогддог тул хүүхэд болон насанд хүрэгчийн хооронд "амьд" харилцаа үүсдэггүй. Ийм тохиолдол гарвал маш хурдан буцаж зохиолын үйл явдал, агуулга руу эргэн орох шаардлагыг тавьдаг. Уламжлалт уншилтад хүүхдийн оролцоо зөвхөн сонсохоор хязгаарлах тул харьцангуй олон хүүхэд хамруулж болдог.

## Харилцан ярилцаж унших

Номоор дамжуулан насанд хүрэгч хүүхэд хоёрын дунд харилцан яриа өрнүүлэх зорилготой нэг төрлийн уншилтын хэлбэрийг харилцан ярилцаж унших гэж нэрлэж байгаа юм. Хүүхэд бүрд номын зураг харагдаж байх, мөн уншиж байгаа хүн хүүхдийн хариу үйлдэл асуулт бүрийг алдалгүй хүлээн авч ярилцах ёстой болохоор  дөрвөөс илүү хүүхэд оролцох боломж бага байдаг. Цэцэрлэгийн нөхцөлд  цөөн хүүхдийн хүрээнд  (10 -аас хэтрүүлэхгүй) том дэлгэцээр номын зургийг харуулж болно. Аль болох тухтай тайван, хоорондоо таатай ярилцах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.
Уламжлалт хэлбэрээр уншихад насанд хүрэгч гол анхаарлаа зохиолын агуулгыг гаргахад анхаарч харин хүүхэд саад бололгүй анхааралтай сонсох үүрэгтэйгээр оролцдог бол харилцан ярилцаж уншихад хүүхэд гол өгүүлэгчийн нэг болж насанд хүрэгчтэй идэвхтэй харилцан ярилцаж, харин насанд хүрэгч идэвхтэй сонсогч, туслагчийн үүргээр

оролцоно. Оролцогч талууд хоорондоо байнга харилцан, ялангуяа хүүхдийн зүгээс ирэх идэвхтэй оролцоо, яриаг онцгойлон хүндэтгэдэг. Насанд хүрэгч хүүхдийн идэвхийг алдалгүй тосч аван улам өргөжүүлж өдөр тутмын амьдралын үзэгдэлтэй нь холбон ярилцаж, хүүхдийг идэвхтэй оролцоог үргэлж урамшуулж магтдаг. Ингэж насанд хүрэгч хүүхдийн асуулт, урмаар чиглүүлэн тэдний идэвхийг улам өдөөж дэмжих үүрэгтэйгээр оролцдог байна. Харилцан ярилцаж уншсанаар хүүхэд эцэг эхтэйгээ (дотно хүмүүстэйгээ) цагийг хөгжилтэй зугаатай хамт өнгөрөөж, тэдний өөрийг нь хүндэтгэн хүлээн авч байгааг мэдэрч, ээж аавдаа болон өөртөө итгэх итгэл нь нэмэгдэхийн зэрэгцээ хэл яриа, харилцааны чадварт нь мэдэгдэхүйц ахиц дэвшил гардаг байна.

## Харилцан ярилцаж унших хэлбэрийг судалсан байдал

Доктор Гровер Вайтхурст нарын судалгаагаар сургуульд орж байгаа нийт хүүхдийн 35 хувь нь хэл ярианы хоцрогдолтой гэж оношлогджээ. Энэ нь сургуульд ороод үеийнхнээсээ сурлагаар хоцрох шалтгаан болсон байв. Эдгээр хэл ярианы хоцрогдолтой хүүхдүүдийн ар гэрийн байдал ч бусад хүүхдүүдээс тааруу байжээ. Эхлээд тэдгээр хүүхдүүдийн хэл ярианы чадварт үнэлгээ хийхэд үе тэнгийнхнээсээ бүтэн нэг жилээр хоцорсон байлаа. Ингээд хоцрогдолтой хүүхдүүдэд өдөрт



хамгийн багадаа нэг удаа 10 минут харилцан ярилцах уншилт явуулж, зургаан долоо хоног туршаад дахин үнэлгээ хийж үзэхэд үр дүн нь хүлээж байснаас хамаагүй амжилттай гарсан байна. Тухайлбал:

- Үе тэнгийнхнээсээ хэл яриагаар бүтэн жилээр хоцорсон байсан эдгээр хүүхдүүд зургаахан долоо хоногийн дараа тэдэнтэй адил түвшинд очиж чаджээ.

- Үгийн баялаг нь тэлж, шинэ шинэ ухагдахууны утга учрыг сурч ойлгосон байв.



Дараагийн гайхалтай эерэг үзүүлэлт бол харилцан ярилцаж унших явцад өөрийг нь хүндэтгэн, магтаж урамшуулсан, үнэлсэн харилцаанаас хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж эрс дээшилсэн байв. Энэ ахиц дэвшил нь богино хугацааны амжилт биш байсан гэдгийг урт хугацааны судалгаагаар ч баталсан байна (1994. Вайтхурст). Хүүхэд багаасаа номтой харьцаж хэвших нь уншиж бичиж сурахын өмнөх шат, үндсэн суурь нь болж өгдөг. Хүүхдийн ирээдүйн сурлагын амжилтын хамгийн гол нөхцөл болсон уншиж бичих чадвар, харилцааны болон сурах арга барилыг харилцан ярилцаж унших аргаар дэмжин хөгжүүлэх нь маш үр дүнтэй арга гэж орчин үед дэлхий нийтээр үнэлж байна.
Гэхдээ харилцан ярилцаж унших хэлбэр бол бусад уншилтын хэлбэрүүд ялангуяа уламжлалт хэлбэрийг шахан зайлуулж байгаа гэсэн үг биш юм. Харилцан ярилцаж унших хэлбэр нь ялангуяа бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд хамгийн тохиромжтой, гэр бүлд хэрэгжүүлэхэд хялбар гэдгээрээ онцлогтой юм. Харин ахиц дэвшил энэ хэлбэрийн уншилтыг тогтмол, удаан хугацааны туршид явуулсны дүнд гарна.



# III

# ХҮҮХДЭДЭЭ УНШИЖ ӨГӨХ НОМ ЗОХИОЛОО ХЭРХЭН СОНГОХ ВЭ?

Эцэг эхчүүд хүүхдийнхээ өсөлт хөгжлийн онцлогийг сайтар мэдэж байх нь тэднийг зөв ойлгож дэмжиж туслахад ихээхэн ач холбогдолтой. Түүнилэн хүүхдээ номонд дуртай болгоход тэдний нас сэтгэхүйд тохирсон номыг зөв сонгох явдал хамгийн чухал. Хэт хүндэдсэн мэдээлэлтэй ном тэднийг ядрааж дургүйцүүлдэг бол хэтэрхий энгийн (хөнгөдсөн) номыг сонговол сонирхлыг нь бууруулж мэднэ. Тиймээс хүүхдэдээ ном сонгож авахдаа тэдний насанд тохирсон эсэхийг нь хамгийн түрүүнд харж үзэх хэрэгтэй. Ялангуяа хүүхдийн нас бага байх тусам хөгжил нь маш хурдацтай явагддаг, өдөр сараар хэмжигдэж байдаг тул хүүхдийн номонд насыг нарийвлан заах учиртай. Сургуулийн өмнөх насны хүүхдийн насыг сэтгэхүйн онцлог, хэл ярианы чадварын нийтлэг шинжийг харгалзан 3 ангилан хувааж үзэж болно. Үүнд:

- 0-2 нас Энэ үедээ хүүхэд мэдрэхүйн эрхтнүүдээрээ дамжуулан орчноо таньж мэддэг.

- 3-4 нас Энэ үеэс эхлэн хүүхэд өөрөө сэтгэн бодох чадвартай болдог. Энэ насны сэтгэхүйн онцлог нь төсөөлөх, төлөөлүүлэх, орлуулах хэв шинжтэй байдаг.

- 5-6 нас Энэ насны хүүхэд эх хэлний үндсэн дүрмүүдийг эзэмшдэг. Тиймээс чөлөөтэй ярих, сэтгэх, харилцах чадварыг хөгжүүлэх зорилгыг голлон анхаарна.

## 0-2 насны хүүхдийн онцлог, тэдгээрт зориулсан ном

- 0-9 сар Хүүхдийг 3 сартайгаас нь эхлэн номтой танилцуулж эхлэх боломжтой гэж үзэн улс орнуудад энэ насны хүүхдэд зориулсан төрөл бүрийн ном гаргасан байдаг. Энэ насны хүүхдэд эхлээд даавуун материалтай, тод өнгөтэй, умхэж базахад бүйл ам, гар хуруу нь

гэмтээж зүсэхээргүй, өнгө будаг гардаггүй номыг авч өгч болно. Тэд номоо амандаа хийх, базах зэргээр мэдэрч эхлэн, улмаар 5-6 сартай хүүхэд эхлээд хурц тод өнгөтэй зургийг нь харж сонирхоно. 7-8 сартайдаа хуудсыг нь эргүүлдэг болж алхам алхмаар номоо эзэмшиж эхэлдэг. Өөрөөр хэлбэл 9 сар хүртэлх үеийг номтой танилцаж дотносох үе гэж нэрлэж болно.

• 9-12 сар Хүүхэд есөн сартайгаасаа элдэв дуу авиаг тогтоож, түүнийгээ дуурайх чадвартай болдог. Өөрийн байнгын хэрэглэдэг эд зүйлсийг танина, ойр зуурын уриалсан үг хэллэгийг ойлгоно. Жишээлбэл, нааш ир, гадаа гаръя гэх мэт. Авахыг хүссэн зүйлээ зааж ойлгуулна, толгой дохих, эсвэл сэгсрэх байдлаар зөвшөөрсөн буюу дургүйцэж байгаагаа илэрхийлнэ. Баяртай гэж гараа даллах, гоё байна гэж алга таших гэх мэт ойр зуурын дохиогоор харилцана. Мөн хүүхэд урьд өмнө зөвхөн бодит зүйлийг харж, мэдэрч, таньж байсан бол одооноос хавтгай зурган дээрээс дүрсийг таних буюу номын зургийг “унших” чадвартай болж эхэлнэ. Энэ бол хүүхдийн оюун ухаанд гарч байгаа маш том алхам юм. Бодит зүйлийг хийсвэр зургаас таньж ойлгож байна гэсэн үг. Жишээлбэл, зурган дээрээс халбага, аяга, бөмбөг гэх мэтийг хараад танина. Аав ээж нь энэ үед хүүхэдтэйгээ хамт энгийн хялбар зурагтай ном үзэж, тэдэнд ойлгомжтой үг хэллэгээр тайлбарлан ярилцаж, хамтдаа тоглож харилцах нь хүүхдийн оюун ухаанд гарч буй ахиц дэвшлийг ойлгон дэмжиж байгаа хэрэг юм.



• 12-18 сар Хүүхэд ойролцоогоор нэг настайдаа анхны үгсээ хэлдэг болж, үгийн утгатай дүйцсэн үйл хөдлөл үзүүлж эхэлнэ. Хэлж чаддаг үгийг нь асуувал хариулахдаа дуртай байх ба энэ байдлыг нь дэмжиж ном үзэхдээ мэддэг үгсийг нь оролцуулан ярилцаж болно. Жишээлбэл, "Энэ юу вэ? Өө, нээрээ нохой байна. Нохой яадаг билээ? гэж асуухад хүүхэд "хав хав" гэх мэтээр хариулж чаддаг болно. Харин нэгээс хоёр насандаа хүүхэд өөрийн үгийн санг бүрдүүлж эхлэх ба хэлсэн үг нь бүрэн зөв биш ч гэр бүлийнхэн нь юу хэлэх гэснийг нь ойлгоно. Ойролцоогоор нэг ой хагастайдаа хүүхэд дунджаар 25 үгийг эзэмшсэн байх ба ганцхан үгээр санаагаа илэрхийлж эхэлдэг. Жишээ нь: Май- өг гэсэн утгатай. Мөн "юу вэ? энэ юу вэ?" гэж асууж эхэлнэ. Энэ үеийг нэг үгт өгүүлбэрийн үе гэж нэрлэдэг.



• 18-24 сар Нэг нас зургаан сартайгаас хоёр хүртэл насандаа хүүхэд тань хангалттай үг мэддэг (50 орчим) болж хоёр үгт өгүүлбэр хэлж эхэлнэ. Жишээлбэл, "Гадаа үүдэн" - гадаа машин явж байна гэсэн санаа. Энэ үед хүүхэд өөрөө бүтэн өгүүлбэрээр ярьж чадахгүй ч бусдын яриаг сайн ойлгох болсон байна. Тэд хоол идэх, тоглох, дэлгүүрээс



юм худалдаж авах, унтах зэрэг өөрсдийнхөө өдөр тутмын амьдралаас аль хэдийнээ мэддэг болсон үйлдлүүдийг номын зураг хялбар өгүүлбэрүүдээс маш сайн ойлгоно. Эдгээр үйлдлүүдтэй холбоотой үгс, янз бүрийн амьтдын нэр, тэдгээрийн үйлдлийг хичээнгүйлэн цээжлэхээс гадна танил шүлэг, дууны мөрүүдийг их л тааламжтай дахин дахин давтан сонсох дуртай байдаг. Мөн аяыг нь дуурайхыг оролдон гар хөлөө хөдөлгөн дуулах, бүжиглэхийг оролдож эхэлж байгаа нь тэд хөдөлгөөний эрхтэнүүдээ илүү хянаж, удирдаж сурч байна гэсэн үг. Зурагтай дууны ном хүүхдийн аль ч насанд хэрэгцээтэй. Гэхдээ дууны үг, өгүүлбэрийн хүнд, хөнгөн, утга санаа харилцан адилгүй байдгийг харгалзан үзээрэй.

• 24-36 сар Хоёр настай хүүхдийн зөвхөн хэл яриа ч биш аливаа зүйлийг сурах үйл явц нь хөдөлгөөнийхөө тусламжтайгаар төлөвшин хөгжиж байдаг. Эцэг эхчүүдэд хүүхдийнх нь энэ идэвхтэй хөдөлгөөн заримдаа ядаргаатай мэт байдаг. Харин хүүхэд өөрийнхөө бие бялдрыг ингэж сайн мэдэрч, бие эрхтэн, хөдөлгөөнөө сайн захирч удирдаж, өөрийгөө бүрэн ачааллад байлгаж сурвал энэ нь балчир хүүхдийн хувьд хэл яриа сурах, танин мэдэх хожим сургуульд ороод суралцахад нь анхаарлаа өөрөө удирдан сайтар төвлөрүүлж чадах эх суурь нь болж өгдөг.



Хоёр ой хагастай хүүхдийн үгийн сан маш эрчимтэй нэмэгдсээр ойролцоогоор 150-200 үгтэй болно. Үгсийг хэлэхэд арай хялбар болсон байх ч хараахан бүрэн гүйцэд зөв хэлж чадахгүй. Энэ үе бол хүүхдүүдийн шинэ үгс идэвхтэй цуглуулдаг онцгой үе юм. Хэрвээ таны хүүхэд бүхэл өдрийн турш элдэв зүйлийг нэрлэн нэхэж, асууж эхэлбэл та төвөгшөөж хэрхэвч болохгүй. Хүүхэд зөвхөн хэлний

чадвараа дээшлүүлээд зогсохгүй бас өөрийгөө илэрхийлэхэд давхар суралцаж байгааг ойлгох хэрэгтэй. Энэ үед нь хүүхэдтэйгээ үгийн санг нэмэгдүүлэхэд зориулсан зурагт номуудыг хамтдаа үзээрэй.

## 0-2 насны хүүхдэд зориулсан ном

0-2 насны хүүхдийн ном хялбар урагдахгүй зөөлөн даавуун материалтай, гарт нь эвтэйхэн, эсвэл шидэх, норгох, тоглох, ноолох зэрэг хүүхдийн хөдөлгөөн, гарын ая даах эдэлгээ сайтай, хатуу картонон хуудастай, хүүхдийн гар хөл амыг гэмтээчихээргүй дугуй ирмэгтэй, будаг гардаггүй байх шаардлагатай. Тоглоомын хэлбэр оруулсан, дуугардаг, хуруугаараа тэмтрэн мэдрэхэд зориулан өөр өөр материал ашиглан хийсэн байж болно. Сөхдөг, түлхдэг, дардаг дүрсүүдтэй байвал хүүхэд илүү сонирхолтой байдаг. Энэ бүгд нь тухайн насны хүүхэд харах сонсохоос гадна амтлах, үнэрлэх, хүртэх мэдрэхүйгээрээ суралцдаг онцлогтойг давхар бодолцсон хэрэг. Ой хагас хүртэл насны хүүхдийн номын дүрсүүд нь хоорондоо уялдаа холбоогүй, зураг дээрх дүрсүүд том, гол нь хүүхэд танихад хялбар, үг өгүүлбэр байхгүй, эсвэл богино тайлбартай, 10 хүртэлх хуудастай байвал зохимжтой. Харин ой хагастайгаас гурван нас хүртэлх хүүхдийн номын дүрсүүд нь хоорондоо уялдаа холбоотой болж ирнэ. Мөн богино тексттэй байж болно. Агуулга нь хүүхдийн өдөр тутмын амьдралтай холбоотой байх нь чухал.



## 3-4 насны хүүхдийн онцлог



Гурван настай хүүхэд үсрэнгүй хөгждөг. Хамгийн анзаарагдахаар тэсрэлт тэдний хэл ярианд гардаг юм. Гурван наснихаа төгсгөл гэхэд охид хөвгүүд 800 -1000 орчим үгийн нөөцтэй болж эх хэлнийхээ хэлзүйн үндсэн дүрмийг бараг эзэмшсэн байдаг. Гэхдээ тэдний бусдын яриаг ойлгох чадвар нь өөрсдийнх нь хэл ярианы чадвараас илт давуу байсаар байна. Энэ нь хүүхэд хэдий сайн ойлгож байгаа ч, тэр ойлгосныхоо хэрээр хэлж ярьж хараахан чаддаггүй гэсэн үг. Энэ байдлыг “сургуулилж” байж тэнцвэржүүлдэг, тэр дундаа хэн нэгэн түүнийг сонсож, зөв үгээ олж хэлэхэд туслах ёстой гэсэн үг. Тэр хүн нь эцэг эх болон багш нь байна.

3-4 настай хүүхэд аливаа мэдлэгийг өөртөө сорох мэт гайхалтай шингээж авч чаддаг. Сургуульд ороод уншиж, бичиж сурахад өмнө нь эзэмшсэн байвал зохих олон төрлийн чадвар шаардлагатай байдаг. Зарим нэгийг нь эцэг эх дэмжиж хөгжүүлэх хэрэгтэй байдаг бол зарим нь тохирох орчин бүрдсэн бол өөрөө аяндаа хөгждөг. Тийм аяндаа хөгждөг чадварын нэг бол зурах. Харандаа аваад цаасан дээр эрээчих дургүй хүүхэд гэж бараг байдаггүй. Өөрийн гараар элдэв дүрс гаргах нь тэдний хувьд хачин сонирхолтой үйл явц билээ.

Эцэг эхчүүд харин хүүхэд инээж сараачиж эхэлж байж аажмаар зураг зурах явц руу шилждэгийг тэр бүр ойлгодоггүй. Хүүхдийнхээ зураг зурахыг дэмжсэнээр тэдний хийсвэрлэн бодох сэтгэлгээг хөгжүүлэхэд тус болж чадна. Түүнээс гадна зураас, дугуй, гурвалжин,

дөрвөлжин дүрсийг зуруулж бичүүлж дадлагажуулснаар ирээдүйн бичиж сурахад бэлтгэдэг. Бичиж сурахад шууд хамааралтай биш ч, хүүхдийн хөгжилд чухал нөлөө үзүүлдэг зүйл бол хөгжим, биеийн тамир. Хөгжим зөвхөн хэмнэл мэдэрч сурахад биш бас тархин дахь хэл ярианы төвд нөлөөлж, хөгжүүлж байдаг. Тиймээс та хүүхдэдээ дуу сайн зааж өгч, өөрөө хамт дуулж, хөгжим сонсгож байгаарай. Дуу хөгжмөөр дамжуулж хүүхэд хэмнэл мэдрэн бүжиглэж хөдөлгөөний эвсэлтэй болж, анхаарлаа төвлөрүүлж, биеийн тэнцвэрээ зөв олж, бие эрхтнээ бүрэн ашиглаж сурдаг. Энэ бүхэн нь хожмын уншиж бичиж сурахад чухал урьдчилсан нөхцөл болдог. Тиймээс та хүүхдэдээ идэвхтэй хөдлөх, хөгжим сонсох, дуулж бүжиглэх боломж гэрт нь, цэцэрлэгт нь гарч байгаа эсэхэд анхаарч байгаарай. Хүүхэд өөрийн гэсэн ном эзэмших, эцэг эхээ ном сонин уншиж байхыг байнга харах нь номонд дуртай болоход их нөлөөлнө. Эхэн үед хүүхэд 3-4 номтой байхад хангалттай. Энэ насны хүүхэд аажмаар хүмүүсийн хамтын амьдралын харилцаа холбоог ойлгож, дүрэм журамд захирагдаж суран, бусдын эд зүйлсийг хамаагүй гэмтээж сүйтгэж болохгүй гэдгийг мэддэг болохоос гадна сонголт хийх чадвартай болно. Тиймээс хүүхдэдээ ном авч өгөхдөө болон уншиж өгөхдөө өөрөөр нь сонгуулах, номын дэлгүүрээр дагуулж явах, номын сангаар хамтдаа үйлчлүүлэх, номын бэлэг өгөх зэргээр хүүхдийнхээ идэвхийг сэргээн, номыг үнэлж сургаарай. Таны хүүхэд хэдийнээ номтой харьцаад сурчихсан бол нимгэн хавтас, нимгэн хуудастай ном авч өгөх боломжтой болсон гэсэн үг.



## 3-4 насны хүүхдэд зориулсан ном

Тэд танин мэдэхүйн бүх төрлийн, юмсын учир шалтгааныг тайлбарласан номонд дуртай байдаг. Яагаад? гэсэн асуултад хариулсан, мөн өнгө, дүрс, харьцаа, тооны энгийн мэдлэг олгох, ойлгомжтой богино тексттэй, зурагтай номууд тэдний хувьд их тохиромжтой. Мөн нэмэлт даалгавар бүхий, зурдаг будаг болон нээгддэг сөхөгддөг зурагтай номууд бүр илүү сонирхолтой байдаг. Түүнилэн энэ насны хүүхдэд үлгэр их тохиромжтой. Учир нь үлгэрт сайн, муугийн тэмцэл, зан чанар, ёс суртахууны харилцаа дүрслэгдсэн байдаг. Юу зөв, юу буруу болох тухай сэдэв энэ насны хүүхдэд хүмүүжлийн чухал ач холбогдолтой. Үлгэрт дурлах бас нэг шалтгаан бол тэнд гарах үлгэрийн баатрууд болох шидтэн, шулам гэх мэтийг бодитой байдаг мэтээр хүлээн авдагт оршино. Тэдний ертөнцийг ойлгох ойлголтын онцлог нь бодит болон уран сэтгэмж холилдон байдагт оршино. Тиймээс ч тэдний ургуулан бодсоноо бодит мэтээр ярьдаг энэ үеийг томчууд "худлаа ярьдаг нас" гэдэг. Энэ үедээ хүүхэд болж байгаа бүх үйл явдал өөртэй нь холбоотой гэж ойлгодог. Энэ нь заримдаа буруу ойлголтод хүргэдэг. Жишээлбэл, би үгэнд нь орохгүй байснаас ээж өвдчихсөн гэх мэт. Эцэг эх нь энэ насны хүүхдийн бодлын энэхүү онцлогийг мэддэг бол тэдний



хэрэггүй зүйлээс айх сэтгэлийг ойлгож чадах юм. Мөн зарим үлгэрийн үйл явдал хүүхдүүдэд айдас төрүүлэх тул эцэг эхчүүд анзаарч тайвшруулах, айдас төрүүлэх хэсгийг бага зэрэг зөөлрүүлэн өөрчилж ярьж өгөх, өөрсдөд нь таатай ном сэдвийг сонгуулах зэргээр туслах хэрэгтэй болно. Харин 5 нас хүрэхийн алдад хүүхэд бодит зүйлийг уран сэтгэмжит зүйлсээс ялгаж чаддаг болно. 3-4 насны хүүхдийн ном сэдвийн хүрээ өргөжиж, хийсвэр ойлголтууд болох айдас, бишүүрхэл, ичих гэмших, найз нөхөрлөл гэх мэт сэдвүүдийг хөндсөн ном байж болно. Мөн амьтдын тухай сэдэв голлох сэдэв хэвээр байна. Түүнийлэн зан төлөвийг хялбаршуулан, сонирхолтой байдлаар тайлбарласан, жишээ нь шинэ жилийн баярын тухай гэх мэт номуудыг энэ насныхан их сонирхон үздэг.



## 5-6 насны хүүхдийн онцлог

Энэ насны хүүхэд нэг жилийн өмнөхөөс хол хөгжсөн байна. Хэл ярианы хүрээ илэрхий сайжирч нийлмэл өгүүлбэрээр үйл явдлыг дэс дараалын дагуу ярьж, утга санаагаа бусдад бүрэн ойлгуулж чадна. Маргааш юу хийх гэж бодож байгаагаа, сэтгэлдээ юу мэдэрч байгаагаа, хүсэл мөрөөдлөө илэрхийлэн хэлж чадна. Тэд бүх юмсын ямар зориулалттай, яаж ажилладаг болохыг мэдэхийг хүсч таныг түм буман яагаад? хаана? хэзээ? яаж? яах гэж? гэх мэт асуултаар булах болно. Тиймээс та тэдний асуултад хайнга хандалгүй аль болохоор зөв хариулт өгөхийг хичээгээрэй. Тэд байнга шинэ үг сурч түүнийгээ ярианддаа хэрэглэх явц тогтмол явагдаж байгаагаас үг буюу үеийг давтан хэлэх нь элбэг. Энэ нь ээрч түгдэрч

байгаа мэт сонсогдож болох учраас яаран хэл ярианы доголдолтой гэж дүгнэх хэрэггүй. 5-6 настай хүүхдийн өдөр тутмын идэвхтэй хэрэглэдэг үгийн нөөц аль хэдийнээ 2500-3500-д хүрч, харин 13000 орчим үгийг ойлгох чадвартай болсон байна.

Энэ үедээ хүүхэд урьд нь ганцаар тоглодог байснаа больж хэн нэгэнтэй харилцахыг хүсч түүний төлөө өөрийнхөө зүйлсээ ч хуваалцаж, зарим дуртай зүйлээсээ татгалзаж, бусдын сэтгэл хөдлөлийн байдлыг сайтар ойлгож аргадах зэргээр хариу үйлдэл үзүүлнэ, тоглоомонд дүрмийн дагуу оролцож, ялагдал хүлээх нь тийм ч хэцүү биш болох гэх мэтээр нийгмийн харилцаанд суралцаж эхэлж байгаа нь харагдана. 30 хүртэлх тоог тоолно, геометрийн үндсэн хэлбэрүүдийг (гурвалжин дөрвөлжин, дугуй, зууван) танина, эсрэг ялгаатай зүйлсийг (халуун хүйтэн гэх мэт) ойлгож нэрлэж чадна. Цаг хугацааны талаар зөв мэдлэгтэй болсон байна. Хялбар дүрсийг дуурайж зурж чадна. Тэдэнд урлах бүтээлч ажиллагаа болох зурах, будах, наах, барих тоглоомуудыг санал болгон аль болох өөрөөр нь сэтгүүлж бодуулахын тулд хэсэг хугацааг ганцааранг нь байхаар гаргаж өгөөрэй. Харин зурсных нь дараа хоосон магтаад өнгөрөх биш зургийг нь сонирхон юу бодож юу зурсныг нь өөрсдөөр нь яриулж байвал хүүхэд зөвхөн урамшаад зогсохгүй тэдний хийсвэрлэх сэтгэлгээ, хэл яриа, өөрийгөө илэрхийлэх чадварт нь нэмэр болдог. Энэ насны хүүхдийн уран сэтгэмжид хил хязгаар байхгүй. Ёсзүйн наад захын хэм хэмжээг ухамсарлаж мэддэг болсон байна. 5 нас хүрэх алдад хүүхэд бодит байдал, хүсэл мөрөөдөл хоёрыг



ялгаж салгаж чаддаг болно. Энэ нь зөвхөн тэдний тоглоом, ярианаас харагдахаас гадна шийтгэл, загнуулахаас айхдаа мэлзэх, таныг хуурахыг оролдохоос бас харагддаг. Энэ нь түүнийг хүмүүжил муутайг харуулж байгаа хэрэг биш, энэ насны бас нэг онцлог. Тиймээс та түүнийг ингэж хуурахад яагаад дургүй байгаагаа сайн тайлбарлаж өгөөрэй. Хамгийн гол нь түүнийг худалч хуурагч гэж нэрлэхгүйгээр түүний худлаа хэлүүлж сургахгүйд байгаа юм шүү.

## 5-6 насны хүүхдэд зориулсан ном

5-6 нас бол адал явдалд хорхойсон, удаан сууж анхааралтай дуустал сонсож чаддаг болсон нас юм. Гэхдээ л тэдний номонд зураг маш чухал үүрэг гүйцэтгэх хэвээрээ байна. Харин тэд зургийг нь хараад үйл явдлаас ойлгосноо ярих, дахин дахин уншуулсны эцэст цээжилсэн байх, тэр ч бүү хэл зарим содон үг, зурагтай холбоотой үгийг номоос таньж чадах нь цөөнгүй. Энэ нь тэднийг сургуульд орж уншиж бичиж сурах чадвартай болсныг харуулж байгаа юм шүү. Төрлийн хувьд улам өргөжиж адал явдалт, уран зөгнөлт, хошин шог зохиолуудыг илүү сонирхох болно. Хөвгүүд танин мэдэхүйн номонд илүү дуртай байх нь бий.
Сэдвийн хувьд хүрээ нь улам тэлэх тул тухайн хүүхдийнхээ хувийн сонирхлоос гадна, хүйсийн, хөгжлийн ялгаатай байдлаас хамаарах сонирхлоос шалтгаалж сонголтоо хийх нь зөв. Эцэг эхчүүд тухайн номын тавьсан зорилго, хүүхдийн насны онцлог, сонирхолд нийцсэн эсэхийг харгалзан үзэхгүйгээр зүгээр л хүүхдэдээ "хөөрхөн юм" уншиж өгөхөөр сонголтгүйгээр ном худалдан авах нь элбэг ажиглагддаг. Зурагт номыг сонгохдоо нэлээд хэдэн шалгуурыг харгалзан үзэхээс гадна өөрийн тавьсан гол зорилгодоо тохирох эсэхийг нягтлах хэрэгтэй. Ямар зорилгоор хэрхэн ашиглах тухай номон дээр байдаггүй

тул ном сонгохдоо өөрийн зорилгодоо нийцэх эсэхийг эхлээд бодох хэрэгтэй.

## Зурагт ном үзэхийн зорилго

Зурагт ном нь хүүхэдтэйгээ хамт цагийг зугаатай өнгөрүүлэхээс гадна дараах сурган хүмүүжүүлэх зорилго, ач холбогдолтой. Үүнд:

- **Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих:**
  Номыг хуртэж мэдрэх, зураг ажиглах болон сонсох гэх мэт явцаар мэдрэхүйн идэвхтэй оролцоотойгоор дамжуулан танин мэдэхүйг дэмжих

- **Санал бодлоо илэрхийлэх, чөлөөтэй ярих чадварыг дэмжих:**
  Хүүхэд төрсөн сэтгэгдэл, тэдний асуулт, насанд хүрэгчийн асуултад хариулах тэдний хариулт зэрэг аяндаа үүсч гарсан чөлөөт ярианууд хэл ярианы чадварыг улам хөгжүүлдэг.

- **Сурах арга барилд сургах:**
  Зурагт ном хүүхдийн анхаарлаа төвлөрүүлэх чадвар, ой тогтоолт, тэсвэр тэвчээрт суралцах дасгал болдог.

- **Сэтгэхүйг хөгжүүлэн дэмжих:**
  Төсөөлөн бодож ухаж ойлгон, өөр бусадтай харьцуулах, төлөөлүүлэх, өөрт ямар нэг



сэтгэгдэл төрөх зэрэг нь хүүхдийн сэтгэн бодох чадварыг дэмжиж байдаг: Сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх. Ухаж, төсөөлж, ургуулж, харьцуулах, төлөөлүүлэх гэх мэт сэтгэхүйн үйлдлүүд хийгддэг.

- Асуудал шийдвэрлэх чадварыг дэмжих:

Номын агуулгатай холбон, жишээлбэл жилийн дөрвөн улирлын тухай номоор юмсын холбоо харилцааг таниулах юмуу эсвэл цэцэрлэгийн тухай номыг цэцэрлэгт орохоос нь өмнө буюу цэцэрлэгт дасан зохицох эхний үеүдэд уншиж өгөх гэх мэтээр ямар нэг тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байж болно.

- Агуулгаар нь дамжуулж хүүхдэд мэдээлэл өгөх:

Номын баатрууд нь хүүхдэд өдөр тутмын асуудлыг шийдвэрлэхэд үлгэр дуурайл болдог. Жишээ нь: туслч, эелдэг, цэвэрч байх нь зөв гэдгийг номынхоо баатруудаас олж хардаг.
гараа угаадаг цэвэрч хүүхэд өвчин тусдаггүй, бусадтай эелдэг харьцахад гануаарддаггүй гэх мэт жишээг номоос олж хардаг.
Нуулгүй хэлэхэд Монголд хүүхдийн номын шаардлага хангаагүй номуудыг хувь хүн, зарим хэвлэлийн газраас худалдаанд зарагдсан байгаа нь харагддаг. Иймээс эцэг эхчүүд та бүхний сонголтод бидний зөвлөгөө бага ч гэсэн нэмэр болно биз ээ.






# IV
# УНШИЖ ӨГӨХӨД УЧИР БИЙ

Анх 1988 онд Вайтхурст багш сурган хүмүүжүүлэгч болон эцэг эхчүүдэд зориулсан харилцан ярилцаж унших арга барилыг боловсруулжээ. Ингэхдээ онцлог хэл ярианы чадварын ерөнхий түвшинг харгалзан үзжээ. 0-6 насны хүүхдэд хамаатай ерөнхий зарчим нь насанд хүрэгч идэвхтэй сонсогч, чиглүүлэгч, харин хүүхэд гол өгүүлэгч байх явдал юм. Насанд хүрэгч нь асуулт асууж, идэвх сонирхлыг нь өдөөж, хүүхдийг урамшуулан магтаж, хариултыг нь илүү дэлгэрүүлэх үүрэгтэй. Ингэхдээ зугаатай хөгжөөнтэй хэлбэрээр хүүхдийн хөгжлийг дэмжих хэрэгтэй.

Насанд хүрэгчид хүүхдээс асуух асуулт, тэднийг дэмжих хэлбэрүүдээ хүүхдийн насны онцлогт тохируулан хөнгөрүүлж хүндрүүлэн зохицуулж сурах шаардлагатай.

Зохих хэмжээний хөгжлийн өндөр түвшинд байгаа 5-6 настай хүүхдээс харьцангуй өргөн хүрээнд асуулт тавина. Тухайлбал, өгүүлж байгаа үйл явдлын нийт уялдаа холбоог голлон, өнгөрснийг бататгасан, эргүүлж асуусан асуултуудыг тавих гэх мэт. Харилцан ярилцаж унших хэлбэрийн 5-6 настай хүүхдэд зориулсан арга нь хүүхдийн чөлөөтэй ярих өгүүлэх чадварыг голлон дэмжихэд чиглэнэ.

## 4-6 настай хүүхэдтэй харилцан ярилцаж, ном унших аргазүйн товчоо



Үг аргачлалд хүүхдийн сэтгэлзүйн хэрэгцээг мэдэрч дэмжих, сурах арга барилд сургах, харилцан ярилцах болон үүргээ ээлжлэн солих зэрэг харилцан үйлчлэлт арга барилын олон хэлбэрийг багтаасан болно.

| Насанд хүрэгчийн зүгээс | Дэлгэрэнгүй аргачлал | Хүрэх үр дүн |
|---|---|---|
| Хүүхдийн сонирхлыг харгалзах | Хүүхдийн асуулт, сонирхсон зүйл, хэлсэн үгийг ойлгон хүлээн авч тухайн хүүхдийн сонирхол руу чиглүүлэн асууж, ярилцан дэмжих. | Хүүхэд өөрийнх нь сонирхлыг хүндэтгэн хүлээн авч байгааг мэдрэн урамшиж, цаашид улам идэвхтэй харилцан ярилцана. |
| Бататгасан хариу | Хүүхэд өөрийн хариултаа зөв гэдгийг мэдэж авна. "Яг зөв, энэ бол хулгана" | Хүүхэд өөрийн хариултыг баталгаажуулж авснаар өөртөө илүү итгэлтэй болно. |
| Эерэг хариу мэдээлэл | "Чи бүгдийг нь мэдэж байна шүү", "Сайн байна" гэх зэрэг үгээр хүүхдийг урамшуулна. | Хүүхдийн хэлсэн үгийг сайшааж авч үзэж байгаа тул хүүхэд өөрийгөө хүлээн зөвшөөрч байгааг мэдэрнэ. |
| Санаа өгөх /шаардлагатай бол/ | Хүүхэд дүүгүй байх, өөрт нь ямар нэг санаа орж ирэхгүй тохиолдолд хүүхэд насанд хүрэгчийн санаа авахуулсан үгийг давтах болно. | Насанд хүрэгчийн хэлсэн үгээс давтан хэлснээр санаа авч ойлгон, идэвх нь сэргэнэ. |
| Дэлгэрүүлсэн нэмэлт асуулт | Хүүхдийн хариултыг нэмэлт асуултаар дэлгэрүүлэн яриулна: "Энэ машин ямар өнгөтэй байна вэ?", "Машины энэ хэсгийг юу гэж нэрлэдэг билээ?" | Хэлсэн санаагаа улам дэлгэрүүлэх идэвхтэй болно. |



| | | |
|---|---|---|
| Шууд бус аргаар алдааг засах | Хүүхэд буруу хэлэхэд шууд буруушаалгүй, үгийг алдааг залруулж давтан хэлнэ."Тийм байна, энэ  морь шиг харагдаж байна, гэхдээ энэ бол буга" | Идэвхтэй болон идэвхгүй үгсийг улам баяжуулан бататгана. |
| Дэлгэрүүлэх | Хүүхдийн хэлснийг шинэ мэдээллээр баяжуулан давтан хэлж дэлгэрүүлнэ. | Үгийн баялаг нэмэгдэж, цогц өгүүлбэрийн утга төгөлдөр бүтэцтэй танилцана. |
| Дэлгэрүүлсэн буюу зассан хэллэгийг давтан хэлүүлэх | Зассан буюу дэлгэрүүлсэн өгүүлбэрийг асуулт тавьснаар юмуу давтан хэлэхийг хүссэнээр хүүхэд давтана. | Өгүүлбэрийн бүтцийг өөрийн болгоно. |
| Нээлттэй асуулт тавих | Зураг үзүүлээд юмуу эсвэл "тийм" "үгүй" гэсэн үгээр хариулах боломжгүй дэлгэрэнгүй хариулт авах асуултууд тавих. | Ярианы чадвараа сорих, өөрийн үгээр ярих, уран сэтгэмж хөгжих боломж гарна. |
| Энгийн асуултууд | Хэн? Юу? Хаана? "нөгөө хүн одоо хаана байна? " | Үгийн баялаг нэмэгдэнэ |

| | | |
|---|---|---|
| Дэлгэрүүлэн яриулах асуултууд | Яагаад? Ямар учраас? гэх мэт, үйл явдлыг ухан асууж хамтдаа нарийвлан ярилцах жишээ нь: “Энэ хүү яагаад үйлж байгаа билээ?” | Учир шалтгааны түлхүүрийг олох, өгүүлэгчийн үүргийг гааж авах, уран сайхнаар илэрхийлэх аргад суралцах, задлан шинжилж сэтгэн бодох чадварт суралцана. |
| Сануулан асуух | Зохиолын өнгөрсөн үйл явдлыг сануулан асуух “... ийг санаж байна уу? яаж... яагаад ... лээ? ..ийг гэх мэт” | Учир шалтгааныг олох, үйл явдлын явцыг тодорхойлно. Үйл явдлын загварыг ойлгож авах. |
| Ярианы бус хэлбэрээр сэтгэгдлээ илэрхийлэх | Цочсон, гайхсан гэх мэт мэдрэмжээ нүүрний хувирал, дохио зангаа, болон зурган дээрх хэсгийг заах зэргээр илэрхийлэх. | Анхаарал төвлөрнө, сэтгэгдлээ ярианы бусаар, янз бүрийн хөдөлгөөнөөр “үүлгалан” илэрхийлэх аргад суралцана. |
| Сэтгэгдлээ үгээр илэрхийлэх | Анхаарлыг нь татах зорилгоор “хараач, энд ... байна.” Сэтгэгдлээ илэрхийлэхийг уриалж “Пөөх”, “Гоё байна уу?” гэх мэт. | Анхаарал төвлөрнө, сэтгэгдлээ үгээр илэрхийлэх арга идэвхжинэ. |
| Орчны эд зүйлсийг нэрлүүлэх, тодорхойлуулах | Эд зүйлсийг тодорхойлж, өөр хувилбар үгсээр илэрхийлүүлэх зорилгоор” | Үгийн баялаг нэмэгдэнэ. Нэр томьёо болон үгийн утгыг бататган эзэмшинэ. |





| | | |
|---|---|---|
| | “Энд байгаа юмыг юу гэдэг билээ?”,”Үүнийг юунд хэрэглэдэг вэ? гэх мэт. | |
| Дутуу өгүүлбэрийг гүйцээхийг хүсэх | Өгүүлбэрийг гүйцээлгэх нь ялангуяа шүлэглэсэн зохиолд хэрэглэхэд илүү тохиромжтой. | Авиазүйн мэдрэмж чадвар сайжирна. Учир шалтгааныг олох чадвар сайжирна. |
| Зурагт дүрсэлсний дагуу яриулах (доод түвшинд) | Зургийн үйл явдлыг дүрслэн яриулах, зураг текст хоёрын холбоос үйл явдлыг гаргуулах зорилгоор “За одоо чиний ярих /унших/ ээлж” гэх мэт. | Ажиглах чадвар хөгжих, учир шалтгааныг олох, ярианы чадвар хөгжих мөн бичгийн хэлний элементүүдийг ашиглаж сурах |
| Номын утга санаатай холбоотой сэдвээр яриулах (дунд түвшинд) | Хүүхдийн амьдрал буюу бодит байдлыг зохиолын утга санаатай холбоотой ярилцах: “Чамайг ... ж байхад ямар байсныг санаж байна уу” гэх мэт | Номоос санаа авч өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирна. үгээр илэрхийлэх чадвар хөгжих |
| Уран сайхнаар тайлбарлуулах, үйл явдлыг цааш төсөөлж яриулах, үйл явдлын үг шалтгааныг яриулах (дээд түвшинд) | Зохиолыг цааш үргэлжилж болох хувилбарыг бодуулах, учир шалтгаан, үр нөлөөг тунгаан бодуулах зорилгоор “Энэ хүн яагаад ингэх болов?”, “Энэ явдал яаж төгсөх бол?” гэх мэт асууна. | Учир шалтгааныг олох, зохиолын үйл явдлыг ойлгох, ярих чадвар, уран сэтгэмж, үгээр илэрхийлэх чадвар хөгжинө, зохиолын үйл явдлын загвар, зохиомжийг ойлгох чадвар хөгжинө. |

Дээрх арга техникийг бүтээлч, уян хатан байдлаар хэрэглэх хэрэгтэй. Хүүхэд өөрийг нь тандаж, шалгаж байна гэсэн сэтгэгдэл төрөхгүй байх ёстой. Хүүхдийн яриа төдийгүй элдэв хариу үйлдэл, сэтгэл хөдлөлийн илрэл, харцыг ч алдалгүй анхаарч, хүүхдэд аль болохоор өөрийгөө илэрхийлэх боломж олгох нь насанд хүрэгчийн гол үүрэг юм.

## Харилцан ярилцаж унших арга техник (Шлинкерт 2004)

Харилцан ярилцаж унших хэлбэрийг амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэх арга техникийг Германы сурган хүмүүжүүлэгч Хайнц Шлинкертийн боловсруулсны дагуу толилуулъя:
Харилцан ярилцаж унших хэлбэр нь бүх насны хүүхэд тохиромжтой, чөлөөт цагийг хөгжөөнтэй бөгөөд үр дүнтэй өнгөрөөх арга юм. Үг аргыг эцэг эх болон цэцэрлэгийн багш нар ч хэрэглэж болно. Харилцан ярилцаж унших нь чөлөөт цагаа хөгжөөнтэй бөгөөд үр дүнтэй арга юм. Харилцан ярилцаж унших нь заримын хувьд бүх хүүхдийн номонд тохирох ба бас фото альбом, зурагт сэтгүүл, зурагт атлас зэргийг үзэхэд ч бас хэрэглэж болно. Гэхдээ энэ бүхэн нь хүүхдийн нас, хэл ярианы чадвараас хамааралтайг мартаж болохгүй. Хүүхдийн нас бага байх тусам, номын агуулга бус харилцан яриа голлон, зохиолын агуулга хоёрдахь байранд тавигдах учиртай. Зураг нь хүүхдийн анхаарал сонирхолд нийцсэн, яриа өрнөх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 5-6 настай хүүхдэд номын агуулга чухал болович номоос үүдэн яриа өрнөх нь голлох ач холбогдолтой хэвээр байна.



## Зурагт ном үзэх орчинг бүрдүүлэх



Зурагт ном үзэхэд нь хүүхдийн анхаарал төвлөрлийг шаардах учраас анхаарал нь сарнихааргүй тайван тухтай орчинг бүрдүүлэх хэрэгтэй. Зурагт, радио, гар утас зэргээ унтраасан нь дээр. Юуны түрүүнд хүүхдэд номын зураг сайн харагдахаар суух хэрэгтэй. Буйдан юмуу хивс, дэвсгэр дээр зөөлөн юм налж суугаад хүүхдээ хажуудаа суулгах, тэвэрсэн юмуу өвөр дээрээ авч суувал илүү тохиромжтой. Хүүхдэд таныг биеэрээ мэдэрч байх нь түүнд таатай нөмөр нөөлөгтэй, магадгүй хүүхэд айж болохоор үлгэрийн үйл явдлын үед аюулгүй байдалд байгаагаа мэдрэхэд тус болно. Илүү бүтээлчээр хандъя гэвэл жишээ нь, ном үзэх болгондоо суух газраа гоёмсог алчуураар бүтээх, содон малгай өмсөх зэргээр чимбэл өвөрмөц орчин бүрдэж хүүхдэд илүү хүчтэй сэтгэгдэл төрөх болно. Цэцэрлэгийн нөхцөлд цөөн хүүхдийн хүрээнд (10 -аас хэтрүүлэхгүй) том дэлгэцээр номын зургийг харуулж болно. Ингэхдээ номын зургийг скайнердан компьютер проекторын тусламжтайгаар харуулна. Гэхдээ хүүхэд олон байх тусам хүүхэдтэй харилцан ярилцах, хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөн, хариу үйлдлийг хүлээн авах, дамжих явц саатах сөрөг талтайг анхаарна уу.

## Зурагт ном уншиж өгөх үндсэн гурван арга

Зурагт ном гэдэг нь зургуудаас голчлон бүтсэн байх ба зурагт ном нь хангалттай тексттэй байсан ч зургуудыг үзэж ажиглах явц голлох учиртай юм шүү. Зурагт ном хамтдаа унших гурван төрлийн арга байх ба тэдгээрийг хооронд нь хослуулан хэрэглэж ч болно.

1. Хүүхэд өөрөө зургийг хараад үйл явдлыг зохиож ярих, насанд хүрэгч дөхүүлсэн асуулт, урамшуулан чиглүүлэх тайлбар зэргээр дэмжих
2. Зургийг үзэнгээ уншиж өгөх
3. Зургийг үзэнгээ ярьж өгөх

## Асуулт тавих, урамшуулан чиглүүлэх арга хэлбэр

Дөхүүлсэн асуулт, урамшуулан чиглүүлэх үг нь хэл яриаг хөгжүүлэх зорилгод хамгийн нийцтэй арга юм. Гэхдээ тухайн зурагт үйл явдлын явц дүрслэгдээгүй тохиолдолд уншиж өгөх, ярьж өгөх хэлбэрийг хэрэглэнэ.

### Асуулт

Зурагт ном үзэх зорилгуудыг биелүүлэх үүднээс нээлттэй асуултыг тавих хэрэгтэй. Нээлттэй гэдэг нь хүүхэд тийм, үгүй эсвэл ганц үгээр хариулах боломжгүй асуултуудыг хэлж байгаа юм. Ганц үгээр хариулах асуултууд нь хүүхдийн хариулах боломжуудыг хэт хязгаарлан сэтгэн бодох чөлөөт орон зайг хааж үгээ чөлөөтэй сонгон илэрхийлэх боломжгүй болгодог. (Хэн? юу? хаана? гэх мэт) Харин яагаад? ямар учраас? гэж эхэлсэн нээлттэй асуултууд сэтгэн бодох чадвар, хэл

ярианы идэвхтэй хэрэглээг шаарддаг давуу талтай. Гэхдээ маш ойлгомжтой товч хэлбэрээр асууж, хүүхдэд хариулах хугацаа хангалттай өгөх хэрэгтэй, учир нь хүүхдэд биднээс их хугацаа шаардлагатай байдаг. Асуултууд нь тухайн зохиолын агуулга, дүр болон бас тухайн зохиолоос хүүхдэд төрж байгаа сэтгэгдэл, мэдрэмж болон тухайн хүүхдийн амьдрал дахь төстэй тохиолдлуудын талаар байж болно. Хүүхэд зохиолын үйл явдал, утга санааг ойлгосон эсэхийг шалгасан асуулт асууж болох ч энэ нь уламжлалт шалгалтын хэлбэртэй байж болохгүй. Юмсын учир шалтгааныг олох, сэтгэн бодох үйл ажиллагааг дэмжих зорилготой асуултууд илүү тохиромжтой. Бас арай том хүүхдэд буруу ойлгосон дүр эсгэн хүүхдээр зөв хувилбарыг хэлүүлэх, түүний энэ хувилбарыг жишээгээр батлуулах зорилго тавьсан асуулт ч байж болно. Гол нь зөв хариулт олохдоо биш, алдсан ч хамаагүй өөрөө бодож түүнийгээ илэрхийлэн харилцан ярилцах нь хамгийн чухал юм. Түүнилэн асуулт асуудаг хүүхэлдэй ашиглаж болно. Тэр нь тохиромжтой үед хүүхдээс асуулт асуун, бусад үед хамт сонсож байгаа мэтээр хүүхдэдээ илүү сонирхолтой байдлаар зохион байгуулж ч болох юм.

## Урамшуулан чиглүүлэх

Асуулт тавихаас урамшуулан чиглүүлэх нь хүүхдэд илүү чөлөөтэй өөрийгөө илэрхийлэх боломжийг олгоно. Юуны өмнө хуудас эргүүлэх тоолонд гарч ирж байгаа зураг бүр чиглүүлэх санаа гаргаж



ирж чадна. Тийм учраас шинэ хуудас эргүүлээд хүүхдэд зураг ажиглах хэсэг хугацаа өгч хүүхдийн хариу үйлдлийг ажиглах хэрэгтэй. Хүүхдийн гаргасан дуу авиа, шинэ зураг хараад хэлсэн үгийг урамшуулан дараах байдлаар дэхүүлсэн чиглүүлсэн санааг гаргаж болно.

• Жишээлбэл, энгийн байдлаар санаа сэтгэгдлээ хэлэх (Энд ямар харанхуй байна аа.)

• Анх төрсөн сэтгэгдлээ дуу алдан илэрхийлэх (Хүүе хараач, ямар гоё юм бэ? гэж гайхах, Пөөх! Ороод ирчихсэн байна гээд цочих гэх мэт)

• Зургийн нэг хэсгийг зааж асуух (Муур хүзүүндээ юу зүүчихсэн байна вэ гээд муурын хүзүүг заах гэх мэт)

• Хуудсыг буцаж эргүүлэн харьцуулахыг хүсэх

• Зургийг хараад хүүхэд рүү нухацтай асуусан байдлаар харах

• Зургийн онцгой зориулалттай хэсгийг үзүүлэх (дуу гардаг ном бол дуугаргах, нээгддэг хаагддаг нүдийг нээх гэх мэт)

Урамшуулах аргад ярианы бус хэлбэр нь зөвхөн нүүрний хувирал дуу алдах авиа бас орно. Эдгээрийг мөн ярианы хэлбэртэй хослуулж болно. Номондоо болон бас хүүдэдээ тохирсон арга олохын тулд номоо эхлээд судлах хэрэгтэй. Энэ аргыг хэрэглэхдээ хүүхдийг сэдвээс өөр зүйл рүү хазайхгүй байхад анхаарах хэрэгтэй.

## Ярьж өгөх, уншиж өгөх

Уншигчийн яриа хүүхэд зургаа илүү сайн ойлгоход чиглэх ёстой. Хүүхдийг номын утга санаа руу анхаарлыг нь татахын тулд нэгэн жигд хэмнэлээр уншихаас аль болох зайлсхийж дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

• Дууны чанга сул: Зориудаар дуугаа өндөрсгөх, аяархан болгох, хэвийн хүүрнэх, шивгэнэх

• Хурд: Зориудаар удаашруулах, хэвийн эсвэл хурдасгах, насанд хүрэгчдийн хувьд удаан гэхээр унших, ярих

• Зогсолт: Текст дотроо эсвэл текстгүй зураг гарахад, зургийг сайтар ажиглуулахын тулд түр зогсох

• Давталт: Чухал, сэтгэл түгшээсэн, догдлуулсан хэсгийг дахин давтан унших

• Тодруулах: Текстээс бага зэрэг хазайх, зарим гадаад үг, хүүхэд ойлгохгүй үгийг тайлбарлах

• Өргөлт авах: Үе, үг, өгүүлбэрийн өргөлтийг зөв хэрэглэх, сэтгэлийн хөдөлгөөн, дуу чимээг өргөлттэй хэлэх

• Дууны өнгө: Дүрээр ялгаж бүдүүн нарийн дуугарах

• Биеийн хэлийг хослуулах: Жишээ нь, Маш хүйтэн байлаа гэхдээ "тити" хэмээн чичирч үзүүлэх гэх мэт



Ярьж өгөх нь уншиж өгөхөөс ихэнх тохиолдолд илүү амьд сонсогддог ба текстийг өөртөө буюу хүүхдэдээ зориулан өөрчилж болдог зэрэг давуу талтай. Текстийг хүүхдэдээ ойлгогдохоор үгээр солих, тайлбар зохион нэмэх, хүүхэдтэйгээ холбон ярих, хүүхэд айж болох хэсгийг зөөлрүүлэх буюу хасах, хүүхдээ чөлөөтэй яриулах, илүү хялбар болгох гэх мэтээр өөрчлөх боломжтой. Тэгэхдээ зохиолын гол өрнөл, утга санааг хадгалахгүй бол зургууд нь өгүүлж байгаа зүйлтэйгээ таарахгүй болно. Нэлээд туршлага суусныхаа дараа хэрэглэх нь зүйтэй.

## Зурагт ном уншиж өгөхөд баримтлах дараалал

Зурагт ном хүүхэдтэйгээ хамт үзэхэд энэхүү дарааллыг баримталж болно:

1. Эхлэл буюу танилцуулга: Хүүхдийнхээ сонирхлыг уриалан тухайн сэдэвт татах, гол баатраа танилцуулах. Номоо шууд үзээд эхлэх биш, үг сэдвийн дагуу яриа өрнүүлэх, саяхан болж өнгөрсөн эсвэл болох гэж байгаа үйл явдалтай нь холбон ярилцах, эсвэл энэ хэсгийг дээр дурдсан хүүхэлдэйгээр ярилуулах, номын нэр болон хавтасны зургаас үргүүлан ярилцах, зарим тохиолдолд хавтасны зургийг таглаж байгаад аажим аажмаар ил гарган хүүхдийг хэсэг хэсгээр нь үг нүүрэнд юу байгааг таахад хөтлөх, үг сэдвийн дагуу дуу хамтдаа дуулах гэх мэтээр хүүхдийн анхаарал сонирхлыг татах хувилбарууд байж болно.

2. Гол хэсэг: Энэ хэсэгт дээр дурдсан 3 төрлийн аргыг хэрэглэх нь гол биш харин номын зураг бүр дээр хүүхэд идэвхтэй ярилцахаар зохион байгуулах нь чухал. Хуудас эргүүлээд л хүүхдийг үгээр бөмбөгдөх биш, тэдэнд зургаа тайван



ажиглаж, сэтгэгдлээ хэлэх боломж олгох хэрэгтэй. Дээр дурдсан зураг ном үзэх гурван аргын алинд ч (хууд.45-аас) асуух болон урамшуулан чиглүүлэх аргыг хэрэглэж болно. Үлгэрийн зурагт номын хувьд мэдээж үлгэрийн үг хэллэгийг хэрэглэх нь илүү итгэл үнэмшилтэй учир ярьж өгснөөс уншсан нь дээр байж болох ч бусад аргаас татгалзах хэрэгтэй гэсэн үг биш.

3. Төгсгөл: Төгсгөлийн хэсэгт дараах гурван үндсэн зүйлийг анхаарах хэрэгтэй.

- Бататган шалгах: Хүүхэд үг зохиолын утга санааг ойлгосон эсэхийг мэдэхээр асуулт тавих, хуудсаа буцаан эргүүлж эхний зургийг эцсийн зурагтай харьцуулах, цааш хэрхэхийг төсөөлүүлэх гэх мэт хэлбэртэй байж болно.
- Шилжүүлэх: Номын дүрслэл болон үйл явдлыг хүүхдийн бодит амьдралтай холбон ярилцах хэрэгтэй. Энэ нь амаргүй боловч хүүхдийн хөгжил, төлөвшилтөд маш чухал алхам юм. Зохиолын агуулгатай холбон тавьсан зорилгодоо хүрэхийн тулд энэ алхам маш чухал бөгөөд үүнийг алгасаж болохгүй. Жишээлбэл, "Дөрвөн улирал" номыг үзэж дуусаад саяхан даарснаас болж ханиад хүрсний шалтгаан юунд байсан талаар хүүхэдтэйгээ ярилцаж болох юм. Зөвхөн нэг сайхан түүх сонсгоод тэр түүх таалагдсан эсэхийг асуух нь маш хангалтгүй юм.
- Бүтээлч ажиллагаа: жүжиг тоглох, зураг зурах, баримал, наамал хийх, дуу сурах, дуулах гэх мэт хүүхдэд төрсөн сэтгэгдэл, ойлгосон зүйл зэргээ өөр хэлбэрээр илэрхийлэх боломж олгох.



## Хүүхэдтэйгээ хамт зурагт ном үзэж харилцан ярилцахад анхаарах зүйлс:

• Юуны өмнө анхаарлаа хүүхэд, ном хоёртоо бүрэн хандуул. Хэрэв та өөр зүйлд анхаарлаа давхар хандуулж, яари байгаа бол ерөөсөө ном уншиж эхлэх хэрэггүй. Хоёрын хооронд ийм байдал хүүхдэд анзаарагдаж, сайн үр дүн авч ирэхгүй юм. Та уншиж байгаа зүйлээ дуусгахгүй ч байж болно. Заримдаа түүнд тантай ярилцаж, хамтдаа суух нь номоос илүү чухал байж болно.

• Хүүхдийг идэвхтэй оролцуулах үүднээс хуудас эргүүлэхийг хүсч болох юм. "За миний хүү хуудсаа цааш эргүүлээрэй, юу болсныг нь харъя" гэх мэт. Ингэхдээ дараагийн хуудсанд юу гарахыг хүүхдээрээ таалгах, төсөөлүүлэх нь харилцан яриа үүсэх нэг нөхцөл болно.

• Уншиж байгаа үгээ хуруугаараа зааж байгаарай. Энэ нь хүүхдэд зүүнээс баруун руу бичдэг, үсэг нийлж үг болдог, үг хооронд зай байдаг гэх мэт бичиж, уншиж сурахад хэрэгтэй ойлголтыг шууд суулгаж өгдөг.

• Яагаад? гэсэн учир шалтгааныг асуусан хүүхдийн асуултад үргэлж хариулах хэрэгтэй.



• Хүүхдээ аль болох их магтаарай. Буруу зүйл хэлсэн ч шүүмжлэх огт хэрэггүй. Гол нь хүүхэд өөрөө сэтгэж, ярьж байгаа нь чухал юм. Хүүхдээ зөвхөн үгээр биш инээмсэглэлээрээ ч бас урамшуулаарай.

• Хүүхдийг албадаж болохгүй. Зарим эцэг эх хүүхдээ өөрт нь саад

болоод юмуу гэрээ буулгаад байхаар нь ном үзэхийг албаддаг нь туйлын буруу юм. Мөн хүүхэд аль нэг номонд дургүй байж болно. Яагаад дургүй байгааг нь асуугаад, шалтгааныг нь хүндэтгэн үзэх хэрэгтэй.

• Та ном уншиж өгөхдөө дээр дурдсанчлан зарим үед амьтдын дүрд орж дуурайн дуугарах, сэтгэлийн хөдөлгөөнөө дууны өнгө аясаар, нүүрний хувирлаараа харуулах зэргээр аль болох уран сайхны жүжиглэлт оруулаарай. Аав ээж нь дуу хоолойгоо өөрчлөн жүжиглэхэд хүүхэд илүү сониучирхан, анхааралтай чагнаж, баясах болно. Танд ч бас ном унших нь зугаатай байгааг бяцхан сонсогч хараад ном үзэх нь үнэхээр сайхан зүйл юм байна гэдэгт улам итгэх болно.

• Хүүхэд тань өөрөө ном уншиж байгаа дүр үзүүлбэл түүнийг нь бас хөхүүлэн дэмжээрэй. Энэ нь таны хүүхэд зөв хөгжиж байгаагийн илрэл шүү!





# V
# ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН НИЙТЛЭГ АСУУЛТУУД

## 1. Яг хэдэн настайгаас нь зурагт ном хамтдаа үзэх хэрэгтэй вэ?



Хүүхэд хэдийчинээ эрт номтой харьцаж сурна, ирээдүйд сайн уншигч болох магадлал төдийчинээгээр өсдөг. Хүүхэд 3 сартайгаас эхлэн номтой "танилцах" боломжтой бөгөөд номыг тоглоомын нэг хэлбэр, миний өдөр тутмын хэрэглээ гэж хүлээж авдаг тухай бид өмнөх сэдэвт дурьдсан. Хүүхэд 9 сартайгаасаа жинхэнэ утгаар нь номын доторхийг нь сонирхон үзэж, зургийг нь "унших, ойлгох" чадвартай болж эхэлдэг. Гэхдээ тэр болтол хүүхдэдээ зургуудыг нь харуулж, тайлбарлан ярьж байгаарай. Таны дуу хоолойг сонсоод хүүхэд тань тайван, сэтгэл хангалуун байхын зэрэгцээ удахгүй ярьж сурахад нь сонсголын маш чухал дасгал болж өгдөг. 2 настай хүүхэд хэдийнээ өөрийн үгсийн сантай болж амжсан байх ба 2-3 үгтэй өгүүлбэр хэлж, бас асуулт тавьж эхэлдэг тул аль болох оройтлоо гэхэд 2 наснаас хэтрүүлэлгүй хүүхэдтэйгээ хамт ном уншиж харилцан ярилцаж эхэлсэн байх шаардлагатай.

## 2. Хүүхдэд хэдэн нас хүртэл уншиж өгөх нь зөв бэ?

Өөрөө уншиж, уншсанаа ойлгож чаддаг болтол нь уншиж өгвөл сайн. Гуравдугаар ангид орж байж хүүхэд уншсанаа бүрэн ойлгох чадвартай болдог. Мэдээж сайн уншдаг болсон ч хааяа ном уншуулах нь тэдэнд таатай хэвээр байна.

## 3. Хэн уншиж өгөх нь илүү тохиромжтой вэ?

Ном уншиж өгөх нь их үнэ цэнэтэй сэтгэлийн хандив юм. Итгэл төрүүлсэн аюулгүйн мэдрэмж болон өөрийн сэтгэлээ хуваалцаж ярихад зориулагдсан нөхцөл, таатай



чөлөөтэй орчин, уур амьсгал бүрдэж чаддаг учраас хүүхэд сэтгэлийн таашаал, цэнгэлийг авч байдаг. Аав ээж нь, хамгийн хайртай хүмүүс нь болохоор тэдэнтэйгээ хамт суугаад ном үзэх нь хүүхдэд хамгийн сайхан. Хүүхэд аав ээжийнхээ өвөр дээр хайрыг илүү мэдэрч баяр жаргалтай байдаг. Гэхдээ заавал аав ээж гэлтгүй эмээ өвөө нь, ах эгч нь, багш нь бүгд л уншиж өгч болох нь мэдээж. Гэртээ номтой, аав ээж нь ном уншдаг бол ном амьдралын салшгүй нэг хэсэг гэдгийг хүүхэд багаасаа мэдэрнэ.

## 4. Ном үзэх цагийг өдрийн аль цагт гаргах вэ?

Хүүхдийн амьдралд дадал хэвшил их үүрэг гүйцэтгэдэг. Учир нь тэдэнд цаг хугацааны баримжаа тогтоогүй байдаг учир дадал зуршил нь тэднийг чиглүүлж өгөхөд тусалдаг. Тиймээс эцэг эх нь бага насны хүүхдэд өдөр тутам хийдэг зүйлийг нь аль болох тогтмол цагт, тогтмол хугацаанд дахин давтагдаж байхаар зохицуулж өгвөл тэдэнд илүү хялбар дөхөм болно. Тэгвэл ном уншиж өгөх цагийг өдрийн аль үед гаргавал илүү зохистой байх бол?

Мэдээж тэднийг өлссөн үед нь ч юм уу, гүйж харайж сэтгэл нь хөөрсөн, эсвэл бусад хүүхдүүдтэй тоглож

байхад саад болох нь ухаалаг санаа биш. Харин хүүхдийг тайван байх үед эсвэл тэдэнд тайван байдал хэрэгтэй үед номоо хамтдаа үзвэл тохиромжтой. Энэ нь үдийн хоол идсэнээс хагас цаг орчмын дараа, эсвэл унтахынх нь өмнө байж болно. Өглөө эрт хүүхэд тань бусдаас түрүүлээд сэрчихсэн бол орноосоо босолгүйгээр ном үзсэн ч бас болно. Хүүхдийг орой унтуулахдаа "Үдшийн үлгэр" уншиж өгч хэвших нь хамгийн тохиромжтой. Хурц биш гэрэлд[2] ээжийнхээ, эсвэл аавынхаа дотно дуу хоолойг сонсож, биеийнх нь илчийг мэдрэх нь[3] тайван нойрсох нөхцөл болж өгдөг байна. Мөн хүүхдэд ямар ном уншуулахаа өөрсдөө шийдэх боломж олгодог байх хэрэгтэй. Харин тэднийг ном уншихад албадаж огт болохгүй! Хүүхэд өөрөө хүсч байгаа үед л номоо үзэж унших, ярилцах таатай нөхцөл бүрдэж байна гэдгийг ойлгоорой.

## 5. Ном үзэж ярилцахад өдөрт хэдэн минут төлөвлөх вэ?

1994 онд судлаач Арнолдын туршсанаар өдөр бүр 10 минут харилцан ярилцаж уншихад мэдэгдэхүйц үр дүн хүүхдийн хэл ярианы хөгжилд гарч байжээ. Хүүхдийн наснаас хамаарч 10-30 минутыг ном уншиж өгөхөд зарцуулахад хангалттай байдаг. Бага насны хүүхдийн анхаарал төвлөрөлт богино байх тул үүнээс урт хугацаа шаардлагагүй. Гэхдээ хүүхэд зургийн тухай ярихыг хүсч байгаа бол хүссэн хэмжээгээр нь ярилцаж болно. Ном уншиж өгнө гэдэгт хоорондоо ярилцах, зураг тайлбарлах, эргүүлж батлах, хүүхдийнхээ асуултад хариулах зэрэг олон ойлголтууд багтаж байгаа юм шүү.



[2]гэрэл бүдэг байх нь мелатин хэмээх даавдрыг идэвхжүүлж бие махбодийг тайвшруулан булчинг сулладаг
[3]биед таатай байдлаар хүрэлцэх, намуухан жигд зүйл сонсох нь окситосин хэмээх хайрын даавдрыг ялгаруулан бүх биеэр нь түгээснээр сэтгэл ханамж, тайвшралыг авдаг.

## 6. Хүүхдийн номыг хаана байрлуулах вэ?

Хүүхдийнхээ номыг тэд дуртай цагтаа өөрөө авч үзэж чадахаар гарт нь ойрхон намхан газар байрлуулаарай. Нэлээд олон номтой болсон бол номын тавиурынхаа хамгийн доод талын тавиур дээр байж болно. Жилд нэг удаа номоо цэгцлэх, урагдсан хэсгийг засаж сэлбэх, хэрэглэхгүй номоо хожим дурсамж болгох зорилгоор цааш хийн хадгалах юмуу өөр жижиг хүүхэд, дүү нартаа бэлэглэх зэргээр номондоо эзний ёсоор хандахад нь чиглүүлж өгөөрэй.



## 7. Хүүхэд маань машины зурагтай сэтгүүл авчраад уншиж өг гэх юм? Энэ нь тохиромжгүй сонголт уу?

Өөрөө сонирхож байгаа бол зургийг нь хараад ярьж өгч, харилцан ярилцаж болно. Хүүхдийнхээ сонголтыг хүндэтгэх хэрэгтэй, та хоёрын дунд харилцаа үүсч байгаа нь хамгийн гол ололт юм. Бас өөр төрлийн хүүхдийн номоос сонголт хийх боломж олгоорой.

## 8. Ном уншиж өгч байхад хүүхэд дураараа хуудас эргүүлэх, ном солих гэвэл яах вэ?

Та хүүхдэдээ зориулж ном уншиж байгаа тул хүүхдийнхээ хүслийг харгалзах хэрэгтэй. Заавал уншиж байгаа хэсгээ дуусгах албагүй. Заримдаа түүнд номоос илүү тантай ярилцаж, хамт суух нь гол байж болно.

## 9. Есөн сартай хүү маань их хөдөлгөөнтэй, ном үзэх сонирхолгүй байх юм. Би ном уншиж өгөх нь хэчнээн чухал гэдгийг мэдэх тул үүнд санаа их зовж байна. Яавал дээр вэ?

Хүүхдээ ном үзэх дургүй байхад нь тулгаж болохгүй. Харин номыг хүүхдийн хийх дуртай зүйлтэй нь холбож, аажмаар сонирхлыг нь татах хэрэгтэй.
Үүнд орой оронд нь номоо үзэх, дуу дуулах, хүүхдийн зугаа үг, үгэн тоглоом тоглох зэргээр оролдож болно. Хүүхдийнхээ нэг зүйл хийж байгаад нөгөөд шилжихэд номыг ашиглавал их сайн. Жишээлбэл: Усанд орох тухай номыг усанд орохын өмнө юмуу дараа нь, хоолны тухай номыг хооллохын өмнө юмуу дараа нь гэх мэт. Гадуур зугаалж байхдаа дуу дуулж болно. Ингэснээр хүүхэд үгэнд анхаарлаа хандуулж эхэлнэ. Эцэст нь номуудыг нь хүүхэдтэй ойр, чөлөөтэй хүрэх газар, дуртай газар нь байлгаж ном сонирхохгүй байгааг нь өөрчлөх боломжтой.

## 10. Ном уншиж өгөх үед хүүхэд маань үсэг сонирхоод асуугаад байна. Яах вэ?

Үсэг хөөгөөд зургаар төсөөлөхөө болих вий гэж санаа зовох хэрэггүй. Тэртэй тэргүй хүүхэд зургаа сонирхож байгаа. Бүр албадаж үсэг нүдлүүлэх гэж бас хэрэггүй. Харин асуусан үсгийг нь хэлээд өгч болно. Тэгж байгаад өөрөө аяндаа үсэг нүдэлчихвэл тэрнээс илүү сайн зүйл гэж юу байх вэ.

## Төгсгөлийн үг

Эцэг эхчүүд бид үр хүүхдээ ямагт сайн сайхныг хүсч байдаг ч ирээдүй нь шулуун дардан байна гэсэн баталгаа өгөх боломжгүй билээ. Харин тэдний төлөвшилд шийдвэрлэх нөлөө үзүүлэх боломж бий. Хүний амьдралын эхний таван жилд ууриг тархины хөгжлийн 90 хувь нь явагддаг. Энэ үед хүүхэд орчин тойрноосоо мэдээллийг хүлээн авч хуримтлуулсаар байдаг. Харин долоон наснаас эхлээд хүүхдийн сэтгэхүй энэ хуримтлуулсан мэдээлэл туршлагын дээрээ суурилан цааш гүнзгийрэн хөгждөг ажээ. Хамгийн чухал, байгалиас заяасан гайхалтай эрч хүч, хүсэл тэмүүлэлтэй, физиологийн нөхцөл бололцоо нь бүрдсэн хүний хөгжлийн энэ хамгийн чухал насанд хүүхдээ зөнд нь орхиж болохгүй. Гараа сайн бол барианд сайн гэдэг, ирээдүйн амьдралд нь шийдвэрлэх үүрэгтэй энэ гараа эцэг эх биднээс бүхэлдээ хамааралтайг шинжлэх ухааны шинэололтууд нотолсоор байна.

Гэхдээ хүүхэд бол зоё сайхан, чухал бүхнээр дүүргэх хоосон сав биш! Зөвхөн өөрийнх нь онцлогт тохирсон, өсч хөгжих зохистой орчинг нь бүрдүүлж, бие, сэтгэхүйн хөгжлийг нь дэмжиж чадвал аяндаа ургаж цэцэглэхэд бэлэн байдаг үр юм.

Хүүхдэдээ цаг зав гаргаж багаас нь ном уншиж өгч, харилцан ярилцаж заншвал таны хүүхдийнхээ ирээдүйд өртөг багатай хэрнээ хамгийн үр дүнтэй хөрөнгө оруулалт болно.



# Ашигласан ном материалууд:

Тайра, Масато (2009): Хүүхдэдээ ном уншиж өгөх нь түүний "Сэтгэлийн тархинд" хүрдэг. Токио: Кюмон паблишн.

Хигүчи, Юүичи (2010): Ном унших дадлаар хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх нь. Токио: PHP Institute.

Bruegge, Walburga& Mohs, Katharina (2007): So lernen Kinder sprechen. Muenchen: Ernst Weinhardt Verlag.

Bayerisches Staatsministerium fuer Arbeit und Sozialordnung, Familie und Frauen & Staatsinstitut fuer Fruehpaedagogik (2012): Der Bayerische Bildungs- und Erziehungsplan fьr Kinder in Tageseinrichtungen bis zur Einschulung. Berlin: Cornelsen.

Kraus, Karoline (2005): Dialogisches Lesen - neue Wege der Sprachfoerderung in Kindergarten und Familie. In: S. Roux (Hrsg.): PISA und die Folgen: Sprache und Sprachfoerderung im Kindergarten. Landau, S.109-129.

Mielenhausen, Brigitte Wilmes (2007): Sprachfoerderung fuer Kleinkinder. Freiburg: Herder.

Rau, Micha (2012): Wie man ein wirklich gutes Kinderbuch schreibt. Ulm: Ulmer Manuskripte.

Sunderland, Margot (2010): Die neue Elternschule. Kinder richtig verstehen und liebevoll erziehen. Muenchen: Dorling Kindersley.

Heinz Schlinkert zur Methodik der Bilderbuchbetrachtung: http://www.kindergartenpaedagogik.de/1892.html (07.05.2009)

Stiftung Lesen (2009): Das ABC des Lesens: http://www.stiftunglesen.de/lesestart

http://www.kindergartenpaedagogik.de/513.html

# Хавсралт

## Миний анхны зурагт ном /9+ сар/




Үнэ: 3’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 х 130 мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Миний анхны ном цувралын хамгийн эхний ном болох “Миний анхны зурагт ном” нь 9 сараас дээш насны хүүхдүүдэд тусгайлан зориулж бүтээсэн ном юм. Энэхүү номыг 9 сартай хүүхдүүдийн харааны хөгжил, зураг хүлээн авах чадвар, анхаарал төвлөрөлтийн хугацаа зэргийг бодолцон үзэж, судалсны үндсэн дээр бүтээсэн бөгөөд тухайн насны хүүхдийн эргэн тойронд байдаг эд зүйлсийг оруулж өгснөөрөө онцлогтой. Учир нь ой хүртэлх насны хүүхдүүдэд хамгийн ойр, танихад амар зүйлс бол гэрийн доторх хүүхдийн өдөр тутам хэрэглэдэг юмс байдаг. Энэхүү номоос хүүхэд аяга халбага, угж, хөхөлт гэх мэт зүйлсийг харж, таньж, нэрлэж сурах боломжтой. Мөн харааны хөгжил нь төдийлөн сайн хөгжөөгүй энэ насны хүүхдүүд нэг хавтгай дээрээс олон дүрс бус дан ганц зүйлийг олж харах нь харааны хөгжилд тустай төдийгүй, бодит зүйлсийг хавтгай дээрээс харж таних нь хүүхдийн баруун тархины хөгжлийг дэмжиж, хийсвэр сэтгэлгээг нь хөгжүүлнэ. Хэрвээ эрхэм таны хүүхэд 9-өөс дээш сартай бол та хүүгээ, охиноо номонд дуртай, номоос өөрт хэрэгтэй мэдээллээ олж авч сургахыг хүсч байвал барихад гарт эвтэйхэн, хурц өнцөггүй, хүүхдийн ам, буйлыг гэмтээхгүй, хор нөлөөгүй будгаар хэвлэсэн уг номыг сонгоорой.

## Амьтны тухай миний анхны ном /12+ сар/




Үнэ: 3’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 х 130мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Энэхүү номыг 12 сараас дээш насны хүүхдэд зориулсан бөгөөд тухайн насны хүүхдүүдийн харааны хөгжил, анхаарлын төвлөрөлтийн хугацааг судалсны үндсэн дээр бүтээсэн юм. Амьтад тэр дундаа

амьтдын үр зулзага бага насны хүүхдүүдийн сонирхлыг ямагт татаж байдаг. Энэ насны хүүхдүүдийн насны түвшин, зураг хүлээн авах чадвар зэргийг харгалзан гэрийн тэжээвэр амьтад болон баавгай, туулай гэх мэт хүүхдүүдийн сайн мэдэх амьтдыг хялбар хөнгөн дүрслэлээр, цэвэр дулаан өнгүүдийг ашиглан зурж бүтээлээ. Хүүхэд 1-2 насандаа шинэ үгсийг эрчимтэйгээр цуглуулж, өөрийн үгийн сангаа баяжуулж, бурдүүлж эхэлдэг учир энэ чухал үед эцэг эхчүүд та бүхэн хүүхэдтэйгээ хамт зурагт ном үзэж, муур, нохой, шувуу зэрэг өдөр тутам харж байдаг эдгээр амьтдыг хүүхдэдээ нэрлэн, тайлбарлан ярилцаж хэвших хэрэгтэй.

Миний гэр /18+ сар/




Үнэ: 3’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 x 130мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Энэхүү ном нь 18-аас дээш сартай хүүхдэд зориулагдсан ба хүүхэд гэрийнхээ доторх эд хогшил, гэр бүлийнхнийхээ эдэлж хэрэглэдэг танил дотно зүйлсийг олж харахаас гадна асууж, лавлаж, нэрлэж, ярилцаж сурахад дөхөмтэй. Энэ номыг 1-2 насны хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан хийсэн тул хүүхдийн харааны хөгжилд тустай төдийгүй бодит зүйлсийг хавтгай дээрээс таниулж байгаагаараа хүүхдийн баруун тархины хөгжлийг дэмжиж, хийсвэр сэтгэлгээг нь хөгжүүлэн, үгсийн санд шинэ үгс нэмэгдүүлэхэд тусална. Та “Миний гэр“ номыг хүүхэдтэйгээ хамтдаа үзэж, харилцан ярилцаж цагийг зугаатай өнгөрүүлээрэй.

Миний анхны шүлгийн ном /24+ сар/




Зохиогч: О.Сундуй

Үнэ: 3’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ:130 x 130мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Хоёроос дээш насны хүүхдийн зурагт ном нь сэдвийн хувьд өргөжиж, богино шүлэг, дуу, богино хэмжээний үлгэр, танин мэдэхүйн холбогдолтой энгийн тексттэй болж агуулга нь баяжсан байдаг. Энэ насны хүүхэд танил шүлэг, дууны мөрүүдийг их л тааламжтай дахин дахин давтан сонсох дуртай байдаг. Тиймээс бид энэхүү шүлгийн номоо хэлд орсон

хүүхдийн хэл яриаг зугшруулэх, хэлд ороогүй хүүхдийг ярьж сурахад нь туслах зорилгоор эрхлэн гаргалаа. Уг номонд бага насны хүүхдүүдийн хэл ярианы онцлогийг харгалзан үзэж цээжлэхэд хялбар үг хэллэгүүдийг ашиглан бүтээсэн шинэ шүлгүүдээс гадна  тухайн насны хүүхдүүдийн заавал мэдэх ёстой хуучны шилдэг шүлгүүдийг ч багтаасан. Эдгээр шүлгүүдийг өгүүлэмж сайтай, хөгжилтэй зургуудаар чимэглэсэн.

Миний анхны үлгэрийн ном / 24 + сар /




Үнэ: 3’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 x 130мм

Нүүрний тоо:  18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

агуулга: Аав ээжээрээ үлгэр, өгүүлэг яриулах нь бага насны хүүхдийн хамгийн дуртай зүйлүүдийн нэг байдаг. Бид анх удаа 24 сараас дээш насны хүүхдүүдэд зориулан “Миний анхны үлгэрийн ном”-ыг эрхлэн гаргалаа. Энэ номонд эцэг эхчүүд бидний сайн мэдэх “Өнхрүүш” үлгэрийг сонгон оруулаа. Уг үлгэр нь дахин давтагдах хялбар өгүүлэмжтэйгээрээ бага насны хүүхдэд илүү тохиромжтой. Аав ээж нараа, Өнхрүүшт тохиолдсон хөгжилтэй явдлыг хүүдээ, охиндоо ярьж өгч, Өнхрүүшийн дууг хамтдаа дуулж цагийг зугаатай өнгөрүүлээрэй. Энэхүү ном нь хүүхдийн гарт эвтэйхэн, хурц өнцөггүй. Бага насны хүүхдэд хор нөлөөгүй хүнсний будгаар хэвлэсэн.

Дуу чимээний тухай миний анхны ном / 2+ нас /




Үнэ: 4’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 x 130мм

Нүүрний тоо:  18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Энэ насны хүүхэд элдэв дуу авиа дуурайж, түүнийгээ тогтоох чадвартай болсон байдаг. Тиймээс “Дуу чимээний тухай миний анхны ном”-таны хүүхдэд маш зугаатай хөгжөөнтэй байж, хэл яриагаа сайжруулахад нь туслахаас гадна сонсголын болон харааны ой тогтоолтыг сайжруулах дасгал болж өгнө. Хүүхдийн гарт эвтэйхэн, хурц өнцөггүй энэ номыг амандаа хийсэн ч буйлыг нь гэмтээхгүй. Бага насны хүүхдэд хор нөлөөгүй, хүнсний будгаар хэвлэсэн уг номыг бяцхан үрсдээ сонгон авч өгөөрэй.

## Өнгөний тухай миний анхны ном /3+ нас /




Үнэ: 4’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 x 130мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Та хүүгээ охиноо өнгөний мэдэгдэхүүнтэй болгох, өнгө ялгаж сурахад нь туслах бэрхшээлтэй байна уу? Тэгвэл “Өнгөний тухай миний анхны ном”-оос таны хүүхэд өнгөний тухай мэдлэгийг хялбархан авах болно. Учир нь энэхүү номын хуудас бүр өөр өөр өнгөөр дагнасан бөгөөд тухайн өнгөний бэлэгдэл болсон эд юмс, амьтдын зургийг жишээ болгон харилцан ярилцсанаар та хүүхдэдээ өнгөний тухай хялбархан ойлгуулж өнгө ялган сурахад нь туслах боломжтой. Хүүхдийн гарт эвтэйхэн, хурц өнцөггүй энэ номыг амандаа хийсэн ч буйлыг нь гэмтээхгүй. Бага насны хүүхдэд хор нөлөөгүй, хүнсний будгаар хэвлэсэн уг номыг бяцхан үрсдээ сонгон авч өгөөрэй.

## Дүрсний тухай миний анхны ном




Үнэ: 4’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 x 130мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Хүүхдэд аль болох багаас нь хэлбэр дүрсийг зөв зааж өгч, ойлгуулах нь чухал юм. Энэхүү ном нь хүүхдийн харааны ой тогтоолтыг хөгжүүлэхэд та бүхэнд туслах болно. Хүүхдийн гарт эвтэйхэн, хурц өнцөггүй энэ номыг амандаа хийсэн ч буйлыг нь гэмтээхгүй. Бага насны хүүхдэд хор нөлөөгүй, хүнсний будгаар хэвлэсэн уг номыг бяцхан үрсдээ сонгон авч өгөөрэй.

## Миний анхны тооны ном




Үнэ: 4’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 x 130мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Бага насны хүүхдийн ой тогтоолтыг сайжруулахад дуу шүлэг цээжлүүлэх, дүрс, тоо зэргийг тогтоолгох нь чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Тиймээс

та хүүхэдтэйгээ хамт уг номын зургуудыг тоолон, “Энд хэдэн хурга байна?” гэж асуугаад хамтдаа тоолж хариуг нь гаргах, амьтдыг нэрлэх зэргээр тоо тоолж сурахад нь сонирхолтой байдлаар дэмжин, цээжлэх үйл явцыг хөгжүүлэх боломжтой. Хүүхдийн гарт эвтэйхэн, хурц өнцөггүй энэ номыг амандаа хийсэн ч буйлыг нь гэмтээхгүй. Бага насны хүүхдэд хор нөлөөгүй, хүнсний будгаар хэвлэсэн уг номыг бяцхан урсдээ сонгон авч өгөөрэй.

### Эсрэг тэсрэгийн тухай миний анхны ном




Үнэ: 4’900 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 130 x 130мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN дугаар: 978-99929-0-733-9

Товч агуулга: Хүүхдэд том жижиг, дээр доор, өндөр намын ялгааг тайлбарлан ойлгуулах тийм ч амар биш. Тэгвэл уг номын хөгжилтэй зургуудаар дамжуулан харилцан ярилцснаар эсрэг тэсрэгийн тухай хялбархан ойлгуулах боломжтой. Хүүхдийн гарт эвтэйхэн, хурц өнцөггүй энэ номыг амандаа хийсэн ч буйлыг нь гэмтээхгүй. Бага насны хүүхдэд хор нөлөөгүй, хүнсний будгаар хэвлэсэн уг номыг бяцхан урсдээ сонгон авч өгөөрэй.

## Хүрч мэдэрдэг ном цуврал




Хувцаслацгаая




Амьтад




Хөдөлгөөнт тоглоомууд




Унтлагын цаг

Үнэ: :5900 ₮

Хэмжээ: 135x135

Нүүрний тоо: 14

Товч агуулга: энэхүү номонд бага насны хүүхдийн танин мэдэж болох зүйлийг төрөл бүрийн материал ашиглан бүтээсэн бөгөөд таны хүүхдийн сонирхлыг татаж, сэтгэхүйг хөгжүүлнэ.

# Шинэ үгс цуврал

## Дэлгүүрт




Үнэ: 6’800 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 140 x 140мм

Нүүрний тоо: : 16 нүүр

ISBN дугаар : 978-99962-0-266-

Товч агуулга: Хүүхэд нэгээс хоёр насандаа өөрийн үгийн санг бүрдүүлж эхэлдэг бөгөөд хэлсэн үг нь бүрэн зөв биш ч гэр бүлийхэн нь юу хэлэх гэснийг нь ойлгодог шүү дээ. Нэг ой хагастай хүүхэд дунджаар 25 үгийг эзэмшсэн байх бөгөөд ганцхан үгээр санаагаа илэрхийлж эхэлдэг. Харин хоёр нас хүрэх үед хүүхэд тань хоёр үгтэй өгүүлбэр хэлж эхлэх ба бүтэн өгүүлбэрээр ярьж чадахгүй ч бусдын яриаг маш сайн ойлгодог болсон байна. Энэ насны хүүхдүүд хоол идэх, тоглох, дэлгүүрээс юм худалдаж авах, унтах зэрэг өөрсдийнхөө өдөр тутмын амьдралаас аль хэдийнээ мэддэг болсон үйлдлүүдийг номын зураг, хялбар өгүүлбэрүүдээс маш сайн ойлгоно. Тэгвэл яг энэ насанд нь хүүхдэдээ хэл яриаг нь дэмжин сайжруулахад дөхөм болохуйц “Миний анхны шинэ үгс” цувралыг сонгон авч өгөөрэй.

Уг цувралын “Дэлгүүрт” номыг хүүхэдтэйгээ хамтдаа “уншсанаар” сонирхолтой өнгөлөг зураг, багахан хэмжээний текстээс хүүхэд тань шинэ үгсийг сурах болно.

## Тоглоомын талбайд




Үнэ: 6’800 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 140 x 140мм

Нүүрний тоо: 16 нүүр

ISBN дугаар: 978-99962-0-266-7

“Тоглоомын талбайд” номыг хүүхэдтэйгээ хамтдаа “унших” явцад тоглоомтой холбоотой үгсийн тайлбар зургууд, багахан хэмжээний текстнээс хүүхдийн тань үгсийн сан нэмэгдэх болно.

## Төрсөн өдөр



Үнэ: 6’800 ₮

Хавтас: Хатуу, картон

Хэмжээ: 140 x140мм

Нүүрний тоо: 16 нүүр

ISBN дугаар: 978-99962-0-268-1

Товч агуулга: Энэ насны хүүхэд хоол идэх, тоглох, дэлгүүрээс юм худалдаж авах, унтах зэрэг өөрсдийнхөө өдөр тутмын амьдралаас аль хэдийнээ

мэддэг болсон үйлдлүүдийг номын зураг, хялбар өгүүлбэрүүдээс маш сайн ойлгоно. Эдгээр үйлдлүүдтэй холбоотой үгсийг хичээнгүйлэн цээжлэхээс гадна танил шүлэг, дууны мөрүүдийг их л тааламжтай дахин дахин давтан сонсох дуртай байдаг. Тэгвэл яг энэ насанд нь хүүхдэдээ хэл яриаг нь дэмжин сайжруулахад дөхөм болохуйц “Төрсөн өдөрт” номыг хүүхэдтэйгээ хамтдаа “уншсанаар” сонирхолтой өнгөлөг зураг, багахан хэмжээний текстээс хүүхэд тань уг сэдэвтэй холбоотой олон шинэ үгсийг сурах болно.

## ЯАГААД ЦУВРАЛ

### Дөрвөн улирал




Үнэ: 9’900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 165 x 190мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN: 978-99962-0-269-8

Товч агуулга: Багачууд бүхний толгойд аливаа зүйлсийн учир утгыг танин мэдэх гэсэн хүсэл тэмүүлэл, “Яагаад?” гэсэн асуулт цаг үргэлж эргэлдэж байдаг. Тэгвэл “Монсудар” хэвлэлийн газар, Хүүхдийн номын “Жангар” редакциас эдгээр асуултуудын хариуд 3-5 насны хүүхдүүдэд зориулсан “Яагаад?” танин мэдэхүйн цуврал номуудыг эрхлэн гаргалаа. “Яагаад?” цувралын “Дөрвөн улирал” номыг хүүхэддээ сонгон авч өгч хамтдаа уншаарай. Уг номоос жилийн дөрвөн улирал яагаад солигддогийн учрыг мэдэхээс гадна улирал бүрийн онцлогоос шалтгаалан цаг агаар, байгаль дэлхий, ургамал амьтад хэрхэн хувьсан өөрчлөгддөгийг мэдэж болно. Номын агуулгын талаар баяжуулан тайлбарлаж, харилцан ярилцах нь хүүхдэд өөрийгөө илэрхийлэх боломж олгохоос гадна тэдний ярих чадварыг нь ч давхар хөгжүүлнэ. Уг номыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан сонирхолтой зургаар баяжуулан, бүтээсэн бөгөөд цэцэрлэгийн багш нар ч сургалтдаа ашиглах боломжтой юм.

### Миний цэцэрлэг




Үнэ: 9’900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 165 x 190мм

Нүүрний тоо: 18 нүүр

ISBN: 978-99962-0-381-7

Товч агуулга: Багачуудын толгойд эргэлдэж байдаг үй түмэн “Яагаад” гэсэн асуултуудад хариулт болгон

"Миний цэцэрлэг" номыг сонгон авч хамтдаа уншаарай.
Уг номд хүүхдийн цэцэрлэгт өрнөдөг нэг өдрийн үйл явдлыг энгийн үг хэллэгээр бичиж сонирхолтой, хөгжилтэй зургаар баяжуулсан бөгөөд таны хүүхэд цэцэрлэгт явахгүй гэж зөрүүдэлдэг бол уг номыг сонгоорой. Энэ насны хүүхэд бүхий л зүйлийг сониучирхаж, бас хамтын амьдралын холбоо харилцааг анзаарч, мэдэрч эхэлдэг. Гэхдээ үүнийг өөрийн хүсэлтэй зохицуулж хараахан сураагүйгээс зөрүүд зан гаргах нь бий. Харин ийм сэдэвтэй номыг та хүүхэдтэйгээ хамтдаа үзвэл хүүхэд уг асуудлыг хэрхэн шийдсэнийг аяндаа ойлгон үр дүнд хүрнэ. Хүүхэд номоос өөрийнхөө амьдралд тохиолддог дүр зургуудыг олж харан гайхширч, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгааг дахин дахин яриулсаар хэсэг хугацааны дараа биеэ зөв авч явах, бусад хүмүүсийн саналыг хүндэтгэн үзэх үзэл аажмаар төлөвшин тогтдог байна. Дашрамд хэлэхэд хүүхдэдээ нэг сэдвийг олон уншиж өгөхдөө битгий төвөгшөөгөөрэй. Түүнчлэн ном нь эцэг эхчүүдэд хүүхэдтэйгээ зөрчилтэй асуудлаар ярилцах хамгийн тохиромжтой гарц болж өгдөг. Хүүхдийн өдөр тутмын амьдралд тохиолдож болох зөрчилтэй асуудлуудыг тусгаж, түүнийг шийдвэрлэсэн агуулгатай ном нь эцэг эхчүүдэд дотны туслагч болдог юм шүү.

## Ургамлын амьдрал




Үнэ: 9'900 ₮
Хавтас: Хатуу
Хэмжээ: 165 x 190мм
Нүүрний тоо: 18 нүүр
ISBN: 978-99962-0-380-0

Товч агуулга: "Яагаад?" цувралын "Ургамлын амьдрал" номыг хүүхдэдээ сонгон авч өгч хамтдаа уншаарай. Уг номоос ургамал ногоо, цэцэг жимс хэрхэн яаж ургадгийн учир шалтгааныг олж мэднэ. Түүнчлэн номын агуулгын талаар баяжуулан тайлбарлаж, харилцан ярилцах нь хүүхдэд өөрийгөө илэрхийлэх боломж олгож, тэдний ярих чадварыг нь давхар хөгжүүлж өгнө. Уг номыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан сонирхолтой зургаар баяжуулан, бүтээсэн бөгөөд цэцэрлэгийн багш нар ч сургалтдаа ашиглах боломжтой юм.

## Малчны хотонд




Үнэ: 9'900 ₮
Хавтас: Хатуу
Хэмжээ: 165 x190мм
Нүүрний тоо: 18 нүүр
ISBN: 978-99962-0-381-7

“Яагаад?” цувралын “Малчны хотонд” номыг хүүхдэдээ сонгон авч өгч хамтдаа уншаарай. Уг номоос таван хошуу мал, сүү цагаан идээ, малын ашиг шим, малчдын ажил хөдөлмөрийн тухай маш олон талын мэдээлэл олж авна. Түүнчлэн номын агуулгын талаар баяжуулан тайлбарлаж, харилцан ярилцах нь хүүхдэд өөрийгөө илэрхийлэх боломж олгож, тэдний ярих чадварыг нь ч давхар хөгжүүлж өгнө. Уг номыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан сонирхолтой зургаар  баяжуулан, бүтээсэн бөгөөд цэцэрлэгийн багш нар ч сургалтандаа ашиглах боломжтой юм.

Одой өвгөний байшин




Зохиогч: Кунихико Аояма

Үнэ: 6’800₮

Хавтас: Зөөлөн

Хэмжээ: 215 x 30.5мм

Нүүрний тоо: 32 нүүр

ISBN: 978-99929-0-720-7

Товч агуулга:  Бяцхан одой өвгөн өөрийн мөрөөдлийн байшингаа босгохоор их ажилдаа орно. Гэтэл түүнд хүч хүрэхгүй олон асуудал тулгарах бүрт ойн амьтад нэг нэгээр ирж туслан, харин хариуд нь өөрийн байшиндаа нэг өрөө гаргаж өгөхийг санал болгоно. Одой өвгөний байшингийн зураг анх зурснаасаа хэрхэн өөрчлөгдөж гайхалтай барилга болсныг энэхүү номын гайхалтай зохиомжтой зургуудаас харж болно. Дашрамд хэлэхэд энгийн үг хэллэгтэй одой өвгөний байшингийн түүх нь хүүхдүүдэд аливаа зүйлийг хийхдээ уйгагүй хичээл зүтгэл гаргаж чадвал хэрхэн амжилттай бүтээж болдгийн үлгэр жишээг харуулах болно. Тиймээс хүүхэд хамтын хөдөлмөр түүний ач холбогдолын талаар уншиж мэдэх ба хамтдаа нэг зүйлийн төлөө зүтгэвэл болохгүй бүтэхгүй юм гэж байхгүй болохыг мэднэ. Мөн уг номын зохиол нь хүүхдэд эвсэг хамтач зан чанар төлөвшихөд тусална.

## ДЭЛХИЙН ШИЛДЭГ ҮЛГЭРҮҮД

Ах дүү Гриммийн үлгэрүүд




Үнэ: 9’900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 220 x 280мм

Нүүрний тоо: 80 нүүр

ISBN: 978-99929-0-468-2

Товч агуулга: Энэхүү үлгэрийн номонд “Ойн гурван бяцхан эр”, ”Чоно ба долоон ишиг”, “Эрхийн

чинээ хүү", "Улаан малгайт", "Хэнзель Гретель хоёр", "Гаргүй охин", "Бремений хөгжимчид", "Аз жаргалд умбасан Ханс хүү" гэх зэрэг үлгэрүүд багтсан. Үлгэр нь хүүхдэд сайхан сэтгэл, мөрөөдөл, хүсэл эрмэлзэл төрүүлэхээс гадна, оюун сэтгэхүйг нь хөгжүүлэн цэцэглүүлдэг. Үлгэрийн дүрүүдийн нөлөөгөөр хүүхдийн сэтгэхүйд бий болсон гоозүй, оюун санааны сэтгэлгээ нь тархины үйл ажиллагааг идэхжүүлэн, улмаар ухаан бодлыг цэгцэлдэг байна. Үүний зэрэгцээ хүүхэд шударга ба шударга бус явдлын тухай анхны төсөөллийг үлгэрийн үйл явдлаас ойлгож мэдэрдэг. Үлгэрийн номын зураг нь өнгө дүрслэл сайтай байдаг тул өгүүлэмжийн утгыг ойлгоход илүү дөхөмтэй. Хүн бүхэн сэтгэл татам сайхан дууг сонсоод дагаж дуулмаар санагддаг шиг үлгэр сонсоод өөрсдөө бусдад ярьж өгөхийг хүсэхээс гадна, үйл явдлыг нь ургуулан бодох, зохиомжлон сэтгэх ч тохиолдог байдаг шүү дээ. Энэ нь хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж байгаагийн илрэл юм. Хүүхэд эрдэм мэдлэгийг сургуулиас олж авдаг бол, хувь хүн болох төлөвшлөө үлгэр, туульс хийгээд эрэлхэг баатарлаг үйлсийн тухай сонирхолтой ном зохиолоос олж авдаг гэдэгтэй маргах хүн үгүй биз ээ. Тиймээс хүүхдийг хүний хайр энхрийллийг мэдэрч ойлгодог, нөхөрлөлдөө үнэнч, тусч, сайхан сэтгэлтэй хүн болгоход манай хэвлэлийн газраас гаргаж байгаа үлгэрийн цуврал номууд нэн чухал гэдэгт итгэлтэй байна.

## Ханс Кристиан Андерсний үлгэрүүд




Зохиомжлон найруулсан: О.Сундуй, Д.Болдхуяг, Ү.Мөнхзул
Үнэ: 9'900 ₮
Хавтас: Хатуу
Хэмжээ: 220 x 280мм
Нүүрний тоо: 76 нүүр
ISBN: 978-99929-0-609-X

Товч агуулга: Хүүхдүүдээс Андерсен гэж хэн бэ? гэж асуувал ихэнх нь хариулт хэлэхгүй л болов уу. Түүний оронд "Эрэлхэг тугалган цэрэг", "Хааны шинэ хувцас", "Нугасны муухай дэгдээхий" зэрэг үлгэрүүдийг мэдэх үү? гэвэл нэгэн зэрэг "тийм" гэж хариулна. Эдгээр олон гайхамшигт үлгэрүүдийг дэлхийн бүх үндэстэн өөр өөрийн хэл дээр хөрвүүлэн хэвлэж бага насны хүүхдүүдэд мөн багш, сурган хүмүүжүүлэгчдэд хүртээл болгосноор хүүхдийн сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр иржээ. Бид Андерсений үлгэрүүдийг эх хэлнээс нь орчуулахдаа Монгол хүүхдүүдийн

сэтгэхүйд нийцүүлэн үг хэллэгийг нь найруулсан юм. Андерсений үлгэрүүд нь сайн сайхан үлгэр жишээ, сургамжит санааг агуулсан амьдралын сурах бичгийн эхлэл гэж хэлж болно. Монголчууд бид өөрийн үндэсний үлгэр туульсаас гадна гадаад орнуудын үлгэр, өгүүллүүдийг үр хүүхдэдээ уншиж өгснөөр тэд дэлхий ертөнцийн үй түмэн үйл явдал, сайн муу, болох болохгүйн ялгааг мэддэг болохоос гадна оюун ухааны хөгжил, төсөөлөн бодох сэтгэлгээ, бүтээлч санаа нь хөгжих сайн дасгал болж өгнө.

## Самуил Яковлевич Маршакийн үлгэрүүд



Зохиомжлон найруулсан: З.Түмэнжаргал

Үнэ: 9’900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 220 x 280мм

Нүүрний тоо: 80 нүүр

ISBN: 978-99929-0-692-8

Товч агуулга: Нэрт зохиолч Самуил Яковлевич Маршакийн уран дүрслэл яруу хэллэгтэй үлгэрийн номыг бага ангийн хүүхэд, эцэг эх, багш нарт зориулан хэвлэн гаргалаа. Тус номд “Муурын байшин”, “Цоохор тахиа ба нугасны арван дэгдээхий”, “Арван хоёр сар”, “Тэнэг бяцхан хулганы үлгэр”, “Бяцхан цамхаг” гэх зэрэг үлгэрүүд багтсан. Адал явдалтай, хөгжилтэй энэхүү үлгэрүүд нь бага насны  хүүхдийг номын амтанд оруулах анхны суурийг тавьж өгөхөөс гадна сайхан сэтгэл, үнэнч нөхөрлөл, шударга зан чанартай хүн болж төлөвшихөд ёс суртахуун болон хүмүүжлийн чухал ач холбогдолтой юм

## Хонгорхон Үр Минь Унт даа



Зохиолч О.Сундуй

Үнэ: 16’900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 208 x 234 мм

Нүүрний тоо: 22 нүүр

ISBN дугаар: 978-99962-0-267-4

Товч агуулга: “Хонгорхон хүү минь унт даа” ном нь бага насны хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохирсон олон сайхан шүлгүүдийг багтаасан уг ном нь хүүхэдтэйгээ харилцан ярилцахад тохиромжтой өгүүлэмж ихтэй зураг дүрслэлтэйгээс гадна хүүхдийн тань сэтгэл санааг тайвшруулан, тавтай сайхан амрахад зориулагдсан бүтээл юм. Үдэш бүр багачуудтайгаа үлгэр хэлэлцээд амардаг байсан ардын уламжлал маань орчин үед ингэж хөгжлөө.

## Монгол ардын шилдэг үлгэрүүд




Зохиомжлон найруулсан

В.Нэргүй

Үнэ: 12’800 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 215 х 265мм

Нүүрний тоо: 80 нүүр

ISBN: 978-99929-0-468-2

## “Болдоггүй Бор өвгөн “




/Монгол ардын

үлгэрийн зурагт ном/

Үнэ: ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 206x256 мм

Нүүрний тоо: 28 нүүр

ISBN: 978-99962-0-768-6

Товч агуулга: Уншигч таны гарт очиж буй энэхүү үлгэрүүд нь олон жилийн турш амнаас ам дамжин өвлөгдөж ирэхдээ үе үеийн хүүхэд багачуудын сэтгэлийг хөдөлгөж, үлгэрийн амтанд оруулсан шилмэл үлгэрүүд билээ. Тухайлбал “Цуутын цагаагч гүү”, “Болдоггүй бор өвгөн”, “Өнчин цагаан ботго”, “Алтан мөнгөн аргай” зэрэг үлгэрүүдийг таны аав ээж, эмээ өвөө ч сонсож байсан нь эргэлзээгүй. Ингэж “Үлгэр” хэмээх нандин өв үеийн үед өвлөгддөг билээ. Бидний эмхэтгэсэн “Монгол ардын шилдэг үлгэрүүд” номонд 20 үлгэр багтсан бөгөөд уг ном танай гэрийн номын санд хүндтэй байр эзэлж, хүү, охины тань унших дуртай хамгийн хайртай ном байна гэдэгт бид итгэлтэй байна.

Болдоггүй бор өвгөн. Монгол хүн бүр энэ үлгэрийг амьдралдаа ядаж нэг удаа заавал уншиж сонсдог гэвэл хэтрүүлэг болохгүй. Хурмастай цэц булаалдан дийлдэг арга ухаантай өвгөнийг зөвхөн хүүхдүүд ч бус томчууд, хөгшчүүл ч сайн мэддэг юм. Манай хэвлэлийн компаниас хүмүүсийн дунд танигдан алдаршсан монгол үлгэрүүдээрээ зурагт номын цуврал гаргаж байгаа билээ.

## “Өвгөн бар хоёр”




/Монгол ардын үлгэрийн зурагт ном/

Хавтас: Хатуу

Хэмжээ: 206x256 мм

Нүүрний тоо: 28 нүүр

ISBN: 978-99962-0-471-5

Ард түмний дунд алдаршсан монгол үлгэрүүдээр зурагт номын цуврал цувралын нэг бол арга ухаан сийлэн араатан барыг дийлсэн өвгөний тухай өгүүлдэг ардын үлгэр. Хүүхдүүдийн төсөөллийг хөгжөөх сонирхолтой сайхан зургуудтай.

"Чоно ба долоон ишиг"




/Монгол ардын үлгэрийн зурагт ном/

Үнэ: 12900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 206x256 мм

Нүүрний тоо: 32 нүүр

ISBN: 978-99962-0-766-2

Хүүхэд бүр багадаа уншдаг, зүрх сэтгэлд нь хадгалагдан үлддэг үлгэрүүдийн нэг бол "Чоно ба долоон ишиг" гэдэгт эргэлзэх хэрэггүй биз ээ. Тэгвэл энэ удаад энэхүү үлгэр маань зураг чимэглэл, үг хэллэг, найруулгын хувьд бүрэн шинэчлэгдэж дахин хэвлэгдлээ. Өгүүлэмж сайтай, үлгэрийн үйл явдлыг дэлгэрүүлэн дүрсэлсэн, мэргэжлийн өндөр түвшинд бүтээгдсэн зураглалтай.

"Цуутын цагаагч гүү"




/Монгол ардын үлгэрийн зурагт ном/

монгол зургийн аргаар зурагдаж байгаа.

206x256 мм

Товч агуулга: Унагаа хамгаалсаар хамгаалсаар үрэгддэг Цуутын цагаагч гүүний үлгэрийг сонсоод хүүхэд бүхэн уйлдаг. Монгол хүүхэд бүр үсэг сурахаасаа өмнө, бүр бага байхдаа энэ үлгэрийг хэн нэгнээр уншуулж сэтгэл догдлон догдлон сонсдог. Сургуульд ороод эх хэлний сурах бичгээсээ ч энэ үлгэрийг уншдаг. Хүний сэтгэлийн нандин утсыг хөндөж зүрхэнд хоногшин үлддэг энэ үлгэр олон зууны туршид өгүүлэгдэн бидний үед ирсэн юм. Хүүхдүүдийн хамгийн дотно энэ үлгэрийг монгол зургийн аргаар зурсан гайхамшигт сайхан зурагтай ном болгон хэвлэж байна.

"Царцаа намжил"




/Монгол ардын үлгэрийн зурагт ном/

монгол зургийн аргаар зурагдаж байгаа.

206x256 мм

Хүрээ хийдэд шавилан суусан боловч сурсан эрдэм үгүй нутаг буцахдаа тулсан Царцаа Намжил. “Хүн амьтанд хэлж өгөх ганц маани болтугай зааж өгөөч” гэж багшаасаа гуйсанд, “Харих замдаа харсан бүхнээ цээжил, тэр чинь чамд эрдэм болно” гэж багш нь хэлж гэнэ. Багшийнхаа зааснаар замдаа таарсан бүхнээ цээжилж явах Царцаа Намжилд ямар ямар адал явдал тохиолдсоныг энэ зурагт номоос уншаарай.

“Сэлмэн эвэрт ах дүү гурав”




/ Үлгэрийн зурагт ном/

Хавтас: Хатуу

Хэмжээ: 206x256 мм

Нүүрний тоо: 28 нүүр

ISBN:

“Цэлмэг хөх тэнгэртээ би хайртай”



/Хүүхдийн зурагт ном/

Үнэ: 14900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 206x256 мм

Нүүрний тоо: 32 нүүр

ISBN: 978-99962-0-850-8

Товч агуулга: Уг номын гол баатар нь хөдөө нутагт амьдардаг Номин хэмээх бяцхан охин бөгөөд тэрээр өөрийн гэр бүл, өсөж төрсөн тал нутаг , хөх тэнгэртээ маш их хайртай. Зохиолыг монголоор аялсан гадаад хүн бичсэн бөгөөд зургийг нь нэрд гарч буй залуу зураач Х.Энхномин зурсан юм.

## 108 цуврал

Ардын аман зохиол

ISBN: 978-99962-0-238-4

Бадарчинд тохиолдсон хөгжилтэй явдлууд

ISBN: 978-99962-0-243-8

Домог үлгэрүүд

ISBN: 978-99962-0-242-1

Монгол ардын үлгэрүүд

ISBN: 978-99929-0-81

115x115 мм

24 нүүр

700₮

Уг цуврал нь уншигч хүүхдүүдийг монголын болоод дэлхийн шилдэг үлгэр, зохиолуудтай танилцуулж, номын ертөнц рүү хөтлөх зорилготой юм. Энэ цувралд монгол ардын үлгэр, домгуудаас гадна үр хойч маань өвлөн үлдэх учиртай оньсого, түргэн хэллэг, бэлэг дэмбэрлийн үгс, зүйр цэцэн үгс зэрэг ардын аман зохиолын дээжис багтаж байгаа юм.

## Миний төгөлдөр хуурын ном




Үнэ: 22900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 317x321мм

Нүүрний тоо: 22

ISBN:976-99962-0-339-8

Товч агуулга: Таны хүүхдэд тоглож наадангаа өөрийгөө олон талаар хөгжүүлэх боломжийг энэхүү ном олгох болно. Хүүхдийн хөгжмийн мэдрэмжийг хөгжүүлж, өнгө ялгах, ижилсүүлэх болон аливаа зүйлсийн уялдаа холбоог ойлгож, танин мэдэх чадварт суралцахад энэ шинэ бүтээл туслах юм. Уг номонд багачуудын сайн мэдэх “Маамуу нааш ир”,” Мөн дөө би”, “Гацуурхан”, “Цэцэрлэгтээ явна даа”, “Алаг бөмбөг”,” Тоглоомууд”, “Тоогүй ч юм болов уу даа”, “Мэлхий”, “Найзаа найзаа нааш ир” гэх зэрэг дуунууд багтжээ.
Хүүхэд сурахад хялбар байдлаар хийгдсэн уг номын хөгжмийн даралт нь гэрэлтдэг. Таны хүүхэд гэрэлтсэн товчийг даган тоглож сурах ба хөгжмийн даралт нь өнгө өнгөөр хийгдсэн. Үүний зэрэгцээ нот нь мөн даралттайгаа адил өнгөөр бичигдсэн байгаа тул хүүхдэд маш ойлгомжтой хялбар байх болно.
Хүүхэд хөгжим тоглонгоо сонсголоо сайжруулах, өнгө ялгаж сурах, аливаа зүйлийн уялдаа холбоог танин мэдэх боломжтой.
Таны хүүхэд заавал хөгжимчин болох албагүй ч хөгжмийн мэдрэмжтэй бие хүн болон төлөвшихөд энэхүү ном зайлшгүй хэрэгтэй юм. Мөн төгөлдөр хуур тоглож сурах нь алгебрийн олон үйлдэлтэй тоог бодож сурсантай адил тархинд нөлөөлдөг байна.

## Миний аман хуурын ном




Үнэ: 19’900 ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ: 210 x 289.6мм

Нүүрний тоо: 40 нүүр

ISBN: 978-99962-0-340-4

Товч агуулга: Хөгжмийн боловсрол нь хүүхдийн хүмүүжилд асар их нөлөөг үзүүлдэг. Хөгжим тоглож сурах нь тэвчээртэй, төвлөрч чаддаг, туштай, аливаа зүйлд төгс гүйцэтгэлтэй хандлаг зэрэг дадал зуршлыг бий болгодог. Дэлхийн хөгжмийн урлагийн түүхэнд аман хуур нь авсаархан, тоглож сурахад амархан, эрүүл мэндэд тустай, бие даан суралцах аргыг эзэмшүүлдэг давуу талуудаараа хүүхдийн хамгийн их сонирхдог хөгжмийн зэмсэг гэсэн тодотголыг авчээ. Энэ хөгжмийн

зэмсгийн олон давуу талын нэг бол бүх насныханд зориулсан насны хязгаарлал байхгүй. Өөр хөгжмийн зэмсэг сурч байгаа хүүхдүүд сурахад хамгийн тохиромжтой. Хөгжмийг сурах дасгалын явцад зөв амьсгалын дасгал маш их хийгддэг. Аман хуурыг тоглоход хүчтэй эсэргүүцлийн өөдөөс сөрж, амьсгаа авч гаргахыг шаарддаг. Энэ үйл явц нь мембраныг хүчтэй болгож, гүнзгий амьсгалын тусламжтай уушигны багтаамжийг нэмэгдүүлдэг. Уушгины мэргэжилтэнгүүд аман хуур тоглох нь архагшсан уушигны өвчтөнгүүдийн хувьд амьсгалын замын булчингуудын дасгал болдог ба эсвэл уушигны үйл ажиллагаа, багтаамжийг нь шалгах хэрэглүүр болдог болохыг олж тогтоожээ. Аман хуурыг гарамгай эзэмшсэн ихэнх хөгжимчдийн түүх адилхан байдаг. Үүний нэг жишээ бол аман хуурч Фридрих Ионэтт багаасаа астамтай байжээ. Харин тэр аман хуур тоглодог байсан болохоор насанд хүрэх үед нь өвчин нь эдгэсэн байжээ. Уг номын заавар нь тун энгийн бичигдсэн тул маш ойлгомжтой. Заавал хөгжмийн багш болон хөгжмийн мэдлэгтэй хүнээр заалгах шаардлагагүй 4,5,6,7 гэсэн тоог мэддэг хүн бүхэн тоглож чадна. Мөн номд байгаа дуунууд цомогт бичигдсэн тул сонсоод хамт тоглох боломжтой. Мөн эм үүх дургүй хүүхдүүдэд зориулав. Энэхүү бүтээл нь бүх насны хүмүүс бие даан сурах боломжтойгоороо онцлог. Та ч бас хөгжмийн багш. Тиймээс цаг зав гарган хүүхэдтэйгээ хамтдаа тоглоорой.




Наадам

Үнэ: ₮

Хавтас: Хатуу

Хэмжээ 260x340

Нүүрний тоо:12

ISBN: 978-99962-0-767-9

Энэхүү ном нь наадмын нэг өдрийн үйл явдлыг сонирхолтой, хөгжилтэй үйл явдлаар баяжуулан тайлбар текстгүй дан зургаар илэрхийлсэн бөгөөд 3-5 настай хүүхдүүдэд зориулагдсан. Номын зургаас маш олон үйл явдал, хөгжилтэй зүйлийг олж харах бөгөөд бага насны хүүхдийн анхаарал төвлөрөлтийг сайжруулах дасгал болно. Үүний зэрэгцээ хүүхдийн уран сэтгэмжийг хөгжүүлэхэд тусална.